НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

ИЛ БОЛСОН

МОНГОЛ УЛС
УЛААНБААТАР ХОТ

ERDENES TAVANTOLGOI
ЕТТ

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК**

**БОЛОН**

**“ЭЛГЭН” ХХК-ИЙН**

**ХООРОНД БАЙГУУЛСАН**

# ТАВАНТОЛГОЙ ОРДЫН ДАЛД УУРХАЙН ХАЙГУУЛ, СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

**ГЭРЭЭНИЙ ДУГААР: ЭТТ-2022/946**

Н-ЭТТ-2022/946

**2022 он**

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

## ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .......... 3
ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ .......... 4
ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ .......... 5
ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ .......... 6
ТАВДУГААР ЗҮЙЛ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ .......... 8
ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ .......... 16
ДОЛООДУГААР ЗҮЙЛ. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ .......... 21
НАЙМДУГААР ЗҮЙЛ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР_ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР .......... 22
ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА .......... 25
АРАВДУГААР ЗҮЙЛ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА .......... 26
АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ .......... 26
АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ .......... 27
АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ .......... 27
АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД ЗААЛТ .......... 27

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

ИЛ БОЛСОН

| | |
|---|---|
| **БАТЛАВ**<br>“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ<br><br>Б.ГАНХУЯГ | **БАТЛАВ**<br>“ЭЛГЭН” ХХК-ИЙН ЗАХИРАЛ<br><br>У.ХҮРЭЛБААТАР |

## ТАВАНТОЛГОЙ ОРДЫН ДАЛД УУРХАЙН ХАЙГУУЛ, СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 10 сарын 25 өдөр №ЭТТ-2022/946 Улаанбаатар хот

Н-ЭТТ-2022/946

Энэ гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл заалтууд болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмуудыг үндэслэн:
**Нэг талаас:** 5435528 регистерийн дугаартай **“**Эрдэнэс Тавантолгой**”** ХК (цаашид “Захиалагч” гэх), түүнийг төлөөлж Уул уурхай, технологийн газрын дарга Д.Уужимсанаа
**Нөгөө талаас:** 2745259 регистерийн дугаартай “Элгэн” ХХК, 5478723 регистерийн дугаартай “Литопро” ХХК, 2635003 регистерийн дугаартай “Инженер геодези” ХХК, 5616077 регистерийн дугаартай “Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа” ХХК-иудын “ХАМТАРСАН ТҮНШЛЭЛ”, түүнийг төлөөлж “ЭЛГЭН” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийн захирал У.Хүрэлбаатар нар (цаашид хамтад нь “талууд” гэх) дараах зүйлсийг харилцан тохиролцож “Тавантолгой ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г байгуулав.

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ гэрээний зорилго нь Гүйцэтгэгч нь Тавантолгойн ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажлыг энэ гэрээний Хавсралт №1-тай холбогдон талуудын эрх, үүрэг хариуцлагыг тогтоож талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Гэрээний хугацаанд түншлэлийг төлөөлж “ЭЛГЭН” ХХК гэрээний Ажил /гүйцэтгэл/-тай холбоотойгоор Захиалагчтай харилцана.

1.3 Захиалагч нь гэрээний хугацаанд өдөр тутмын хяналт тавих бөгөөд Захиалагчийн Гүйцэтгэх захирал гэрээнд бүхэлд нь хяналт тавих, гэрээний хэрэгжилтийг сар, хагас жил, жилээр дүгнэх болон гэрээний хугацаа дуусахад гэрээг дүгнэх Гүйцэтгэгчийн төлөөллийг багтаасан төслийн удирдлагын багийг томилно.

1.4 Гэрээний хэрэгжилттэй холбоотойгоор хайгуулын ажлыг удирдаж буй нэгжийн удирдлагын санаачилгаар долоо хоногт хоёроос доошгүй удаа уулзалт зохион байгуулж ажлыг саадгүй, үл ойлголцолгүйгээр хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээг авч ажиллана.

1.5 Энэхүү гэрээ хавсралтын хамт хүчинтэй бөгөөд хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

ИЛ БОЛСОН

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. **"Уурхай"** гэж Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Захиалагчийн эзэмшдэг ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай болон уурхайн бүсийн талбайг бүхэлд нь;

2.1.2. **"Захиалагчийн хяналт"** гэж Хайгуулын ажлыг бүхэлд нь Захиалагч хянах бөгөөд энэ гэрээний дагуу Тавантолгойн ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэхтэй холбоотой үйл ажиллагаанд Захиалагчийн ажилтнууд холбогдох чиглэлийн дагуу хяналт тавьж шаардахыг;

2.1.3. **"Хайгуулын ажлын төлөвлөгөө"** гэж Захиалагчийн төрийн эрх бүхий байгууллагаар батлуулсан тухайн оны хайгуулын ажлын төлөвлөгөө, Гүйцэтгэгчид гаргаж өгсөн тухайн жил, сар, долоо хоног, ээлжийн төлөвлөгөөг, мөн Захиалагч шаардлагатай гэж үзсэн үедээ өөрчилсөн бүхий л төлөвлөгөөг;

2.1.4. **"Гүйцэтгэгчийг үнэлэх үзүүлэлт буюу KPI"** гэж энэхүү гэрээний 7 дугаар зүйл болон гэрээний Хавсралт №2-д заасан гүйцэтгэгчийг үнэлэх үзүүлэлтийг;

2.1.5. **"Гэрээний дүгнэлт"** гэж хуанлийн сар, жил бүр, гэрээ дуусгавар болох үед Гүйцэтгэгчийн хийсэн ажилд Захиалагчийн холбогдох ажилтнууд дүгнэлт гаргаж Төслийн удирдлагын багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсныг;

2.1.6. **"Төслийн удирдлагын баг"** гэж гэрээний 1.4-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр томилогдсон ажлын хэсэг;

2.1.7. **"Салбар"** гэж Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Тавантолгой ордод үйл ажиллагаа явуулах эрх бүхий Захиалагчийн салбарыг;

2.1.8. **"Түншлэл"** гэж Захиалагчаас зарласан Тавантолгой ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтад "Түншлэлийн гэрээ"-ний үндсэн дээр хамтран ажиллахаар оролцсон "Элгэн" ХХК, "Литопро" ХХК, "Инженер геодези" ХХК, "Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа" ХХК-иудын нэгдэл "Хамтарсан Түншлэл"-ийг;

2.1.9. **"Түншлэлийн гэрээ"** гэж "Элгэн" ХХК, "Литопро" ХХК, "Инженер геодези" ХХК, "Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа" ХХК-иудын 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан "Түншлэлийн гэрээ"-г;

2.1.10. **"Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд"** гэж Түншлэлийн гэрээнд заасны дагуу "Элгэн" ХХК-ийг;

2.1.11. **"Үйлдвэрлэлийн осол"** гэж ажилтан гэмтэл, бэртэлд өртсөн, эд хөрөнгөнд хохирол учирсан, үйлдвэрлэлийн алдагдалд орсныг;

ХЭЗГ
№01

Талуудын гарын үсэг

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
ИЛ БОЛСОН

2.1.12. **"Осолд дөхсөн тохиолдол"** гэж үр дагавар нь хүн гэмтэх, байгаль орчин бохирдох, тоног төхөөрөмжийн эвдрэл гарах боломжтой байсан үйлдвэрлэлд нөлөөлөөгүй ажлын алдаатай үйлдлийг;

2.1.13. **"Зөрчил"** гэж уурхайн бүсэд дагаж мөрдөх дүрэм, журам, горим, заавар болон Захиалагчийн баталсан баримт бичгийг зөрчсөн, Захиалагчаас хүргүүлсэн бичгэн мэдэгдлийн дагуу зохих арга хэмжээг авч ажиллаагүй үйлдэл, эс үйлдэхүйг;

2.1.14. **"Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"** гэж байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан Захиалагчийн хайгуулын ажлын байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөө, Захиалагчаар хянуулж, батлуулсан гүйцэтгэгчийн байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөө.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1. Тавантолгойн ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажлыг гүйцэтгэх ажлын хөлс буюу нийт үнэ 69,763,999,500 (жаран есөн тэрбум долоон зуун жаран гурван сая есөн зуун ерэн есөн мянга таван зуу) төгрөг байна. Энэ үнэд гүйцэтгэгчийн гэрээний дагуу гүйцэтгэх бүх үүрэг, үйлчилгээний хөлс НӨАТ болон бусад татвар, хураамж бүгд багтсан болно.

3.2. Захиалагч 3.1-д заасан төлбөрийг Гүйцэтгэгчид дараах хуваарийн дагуу төлнө.

3.2.1. Гэрээний үнийн дүнгийн 30 хувь буюу 20,929,199,850 (хорин тэрбум есөн зуун хорин есөн сая нэг зуун ерэн есөн мянга найман зуун тавь) төгрөгийг гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоногт багтаан төлнө.

3.2.2. Гэрээний үнийн дүнгийн 70 хувь буюу 48,834,799,650 (дөчин найман тэрбум найман зуун гучин дөрвөн сая долоон зуун ерэн есөн мянга зургаан зуун тавь) төгрөгийн үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэгчийн сар бүрийн ажлын гүйцэтгэлээр тооцон олгох бөгөөд гэрээний 3.2.1-д заасан төлбөрийн хэмжээгээр бууруулан тооцно.

3.2.3. Гэрээний хугацаанд үзүүлсэн үйлчилгээний үнэ гэрээний 3.1-д заасан үнэд хүрэхгүй байж болох бөгөөд дутуу захиалсан ажлын төлбөрийг Гүйцэтгэгч талаас нэхэмжлэх эрхгүй.

3.3. Гэрээний үнэд хуульд заасан журмын дагуу үнийн тохируулга хийж болох ба үнийн тохируулга хийх аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд оруулав. /Хавсралт №5/

3.4. Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд нь энэ гэрээний 3.2-д заасан төлбөрийг түншлэлийн бусад гишүүд болон туслан гүйцэтгэгч рүү саадгүй шилжүүлнэ. Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ зүйлд заасан үүргээ биелүүлээгүй нь Захиалагч түншлэлийн гишүүн болон бусад этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.

3.5. Захиалагч тухайн сард хийж гүйцэтгэсэн ажлыг энэ гэрээний 7 дугаар зүйл болон Хавсралт №2-д заасны дагуу тухайн сард гүйцэтгэсэн ажлыг KPI[1] үнэлгээгээр үнэлэх бөгөөд тогтоосон оноонд хүрээгүй бол энэ гэрээний 7.5-д заасны дагуу тооцож тухайн сарын төлбөрөөс суутгана.

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

[1] Key Performance Indicator

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

3.6. Нүүрс болон чулуулгийн хөндлөгийн дээж шинжилгээний үр дүн нь лаборатори хоорондын зөвшөөрөгдөх стандарт зөрүүнээс хэтэрсэн нь 3 дагч лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон тохиолдолд түүнийг төлөөлж буй анхдагч дээжийн төлбөрийг Гүйцэтгэгч нэхэмжлэх эрхгүй бөгөөд тухайн сарын төлбөрөөс суутгана.

3.7. Захиалагч тухайн сард хийж гүйцэтгэсэн ажлыг хянаж баталгаажуулсан төслийн удирдлагын багийн дүгнэлт, Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийг үндэслэн төлбөрийг энэ зүйлд заасны дагуу гүйцэтгэлээр төлнө.

3.8. Энэ гэрээний 3.1-д заасан нэгж үнийн дүнд гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа татвар, хураамж, шимтгэл, ажилтнуудын цалин хөлс, ажилтны нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, тухайн ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх төрлийн даатгал, төлбөр хураамж, тээврийн зардал, ус, цахилгаан, техник хэрэгслийн засвар үйлчилгээ, ажилтнуудын хоол хүнс, орон байр, түлш, шатахуун, тээвэрлэлт, ажил гүйцэтгэхэд шаардлагатай бусад зардал болон эдгээр ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн төлбөр гэх зэрэг энэ гэрээнд заасан бүх төрлийн ажлыг гүйцэтгэхэд гарах зардлууд бүгд багтсан бөгөөд Гүйцэтгэгч 100 хувь бүрэн хариуцан ажиллана.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Захиалагч нь төлбөр тооцоотой холбоотой асуудлаар энэ гэрээний 2.1.10-т заасан зөвхөн түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээдтэй, гэрээний буюу ажлын бүхий л гүйцэтгэл, зааварчилгаа өгөх, ажлын даалгавартай холбоотой асуудлаар "хамтарсан түншлэл"-ийн компаниудтай гэрээний хугацаанд шууд харилцана.

4.2. Гүйцэтгэгчид хайгуулын ажлын төлөвлөгөөг гаргаж өгөх ба хайгуулын ажилтай холбоотой зааварчилгаа, ажлын даалгавар өгөх, ажлын нөхцөлийн дагуу шаардлага тавих, хэрэгжилтийг дүгнэх, ажлын явцад өөрийн компанийн эрх бүхий инженер техникийн ажилтнуудаар хяналт тавьж хайгуулын ажлыг зохион байгуулж ажиллана.

4.3. Захиалагчаас баталсан хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй бөгөөд Захиалагч талын хайгуулын ажлыг харицсан нэгжээс геологийн тогтоц, өрөмдлөгийн үр дүнгээс шалтгаалан төлөвлөсөн цооногийн байршил, гүнийг өөрчлөх, ажлыг түр зогсоох эрхтэй.

4.4. Захиалагч нь өрөмдлөгийн талбай, цооногийн байршлын шав тэмдгийг тавьж өгөх үүрэгтэй.

4.5. Гүйцэтгэгчид хайгуулын ажил гүйцэтгэхтэй холбоотой бичиг баримт болон бусад шаардлагатай мэдээллийг цаг хугацаанд нь түргэн шуурхай өгнө.

4.6. Гүйцэтгэгчээс ирүүлсэн санал, хүсэлт, мэдэгдэлд шуурхай хариу өгөх үүрэгтэй. Эрх бүхий болон бусад байгууллагаар шийдвэрлүүлэх тохиолдолд боломжит хугацаанд хариу өгнө.

4.7. Ажлын гүйцэтгэлд доголдол илэрсэн тохиолдолд Гүйцэтгэгчид /албан бичиг, цахим шуудан, мэдэгдэх хуудас, факс, радио станц, утас болон аман хэлбэрийн аль нэгээр/ мэдэгдэж доголдлыг арилгахыг шаардана.

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

4.8. Гүйцэтгэгчээс өрөмдлөг, цооногийн геофизик, нүүрс болон чулуулгийн шинжилгээ, туршилтын ажил гүйцэтгэхдээ гаргасан технологийн зөрчил, ажлын даалгавар, шаардлагыг биелүүлээгүй зэрэг зөрчлүүдийг бүртгэж, сарын гүйцэтгэлийг энэ гэрээний 7 дугаар зүйл болон Хавсралт № 2-д заасан үзүүлэлтээр дүгнэж үнэлгээнээс хасна.

4.9. Захиалагчийн тавьсан хууль ёсны шаардлага, ажлын даалгаврыг тухайн ээлжинд 2 буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчны ноцтой зөрчил гаргасан Гүйцэтгэгчийн холбогдох ажилтныг хайгуулын ажил гүйцэтгэж байгаа талбайд нэвтрүүлэхийг хориглоно.

4.10. Захиалагч нь хайгуулын талбайд ажиллаж буй бүх төрлийн техник тоног төхөөрөмжүүдэд гэнэтийн болон ашиглалтын явцын, ашиглалтанд орох үеийн үзлэг хийх эрхтэй ба үзлэгээр илэрсэн эвдрэл гэмтэл нь байгаль орчин болон хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөр бол үндэслэл бүхий шаардлага өгч тухайн тоног төхөөрөмжийг зогсоох хүртэл арга хэмжээ авна. Үүнтэй холбоотой үр дагавар, зардлыг Захиалагч хариуцахгүй.

4.11. Техник тоног төхөөрөмжүүдэд үүссэн гэмтлийг бүрэн арилгуулж холбогдох тайланг ирүүлсний дараа тухайн техник, тоног төхөөрөмж, техникийг ажиллуулах зөвшөөрлийг шуурхай олгоно.

4.12. Захиалагч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавьж, шаардлагатай мэдээ мэдээлэл, тайланг Гүйцэтгэгчээс тухай бүр, шуурхай гаргуулж авна.

4.13. Байгаль орчны, ашигт малтмал болон мэргэжлийн хяналтын байгууллага, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн мэргэжилтнүүдтэй хайгуулын ажлын асуудлаар харилцаж, шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд Гүйцэтгэгчээс холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулахыг шаардана.

4.14. Гэрээнд заасан ажил, үйлчилгээг хуваарийн дагуу саадгүй хийж гүйцэтгэхэд шаардлагатай техник тоног төхөөрөмж, байр сууц, байгууламжийг тээвэрлэх, байршуулахад Гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлнэ.

4.15. Захиалагч нь Гүйцэтгэгчид урьдчилан мэдэгдэж хайгуулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэгчийн ажлыг хэсэгчлэн өөрийн санаачлагаар аливаа төлбөр төлөхгүйгээр сул зогсолт хийлгэх эрхтэй.

4.16. Захиалагч нь хайгуулын тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгчийг түлшээр хангаж болох бөгөөд төлбөрийг тухайн сарын гүйцэтгэлээс суутгаж авна.

4.17. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол, зогсолт үүссэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд Гүйцэтгэгчээр гарсан зардал, хохирлыг төлүүлнэ.

4.18. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн болон байгаль орчны холбогдолтой хууль, дүрэм, журам, горим, заавар ноцтойгоор зөрчигдөж хүний амь нас, эрүүл мэнд, эд материал, байгаль орчинд хохирол үзүүлж болохуйц аюултай, эрсдэлтэй нөхцөл байдал Гүйцэтгэгчийн аль нэг ажлын байр болон үйл ажиллагаанд үүссэн тохиолдолд Захиалагчийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчин хариуцсан албан тушаалтан болон хайгуулын үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан тухайн үйл ажиллагааг аюул, эрсдэлтэй нөхцөл бүрэн арилах хүртэл түр хугацаагаар зогсооно. Энэ зүйлд заасны дагуу Гүйцэтгэгчийн үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд Захиалагч Гүйцэтгэгчид сул зогсолтын төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.



НУУЦ
CONFIDENTIAL
ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК
ИЛ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

4.19. Энэ гэрээний хугацаа дуусгавар болсон даруй /24 сарын дараа/ "Хамтарсан түншлэл"-ээс түүний эзэмшлийн хайгуулын хээрийн ажлын зөөврийн байруудыг тоноглолын хамт Захиалагчийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлэн авна.

4.20. Захиалагч гэрээний дүгнэлт танилцуулах, Гүйцэтгэгчийн тайлантай танилцах хурлыг төслийн удирдлагын багийн дарга дараа сарын 10-ны дотор товлон зарлаж хуралдуулна.

## ТАВДУГААР ЗҮЙЛ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

**5.1. ГҮЙЦЭТГЭГЧ НЬ ӨРӨМДЛӨГИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХДЭЭ ДАРААХ БАЙДЛААР ГҮЙЦЭТГЭНЭ.**

5.1.1. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Тавантолгой ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нийт 123,000 тууш метр баганат өрөмдлөгийн ажлыг гэрээний Хавсралт №1-д заасан ажлын даалгаварын дагуу холбогдох горим, стандартын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

5.1.2. Өрөмдлөгийн ажил эхлэхээс өмнө Захиалагч талд өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, арга аргачлал, тоног төхөөрөмийн хүчин чадал, бэлэн байдал, нүний нөөцийн бүрдүүлэлт, туршлага, аюулгүй ажиллагаа хангах заавар зөвлөмж зэргийг багтаасан, танилцуулгыг гүйцэтгэгч талд танилцуулна.

5.1.3. Гүйцэтгэгч нь Захиалагчийн баталсан хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу пасспорт, журам, горим, зааврыг мөрдлөг болгон ажлыг гүйцэтгэнэ.

5.1.4. Гүйцэтгэгч тал нь 8-10 /наймаас-арав/ өрмийн машин тогтмол ажиллах бөгөөд нэг өрмийн машин нь 1500 метр хүртэл өрөмдөх хүчин чадал бүхий хоногт 40 тууш метрийн өрөмдлөг гүйцэтгэх өрмийн машин, өрмийн баг, машин тоног төхөөрөмжтэй байна.

5.1.5. Өрмийн машин тус бүр 200 тууш метр өрөмдөх PQ диаметрийн цооногийн штангтай, 1000 тууш метр өрөмдөх HQ диаметрийн цооногийн штангтай байна. Техник, тоног төхөөрөмж, бусад багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг захиалагч тал ажил эхлэх болон гэрээний хугацаанд хянаж ажиллана.

5.1.6. Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн ажлыг даймонд буюу гулуузан дээжтэй аргачлалаар гүйцэтгэх бөгөөд диаметр нь 63.5 мм буюу HQ хэмжээтэй, байна. Захиалагчийн саналын дагуу өрөмдлөгийн диаметрийг өөрчилж болох бөгөөд дээжийг зориулалтын бат бөх хайрцагт зохих дугаарлалт, интервалын дагуу савлана. Өрөмдлөгийн үйл ажиллагаанд керн бутрах, бохирдох болон холилдохоос сэргийлэх үүднээс нүүрс, чулуунд тогтмол ялтас хэрэглэнэ.

5.1.7. Өрөмдлөгийн ажлын техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй буюу кернийн гарц 95 хувиас бага, нийт нүүрсний давхраасын кернийн 60-аас дээш хувь нь өрөмдлөгийн үйл ажиллагааны улмаас үйрч бохирдсон (ялтас ашиглаагүй өрөмдлөг гүйцэтгэсэн), зорилтот гүн хүртэл өрөмдлөгийн үйл ажиллагаа явагдаагүй, өрмийн шингэн болон бусад зүйлээр бохирдсон, хэт нунтаглагдсан, тээвэрлэлтийн явцад эвдэрч гэмтсэн энэ нь шинжилгээнд сөргөөр нөлөөлөх тохиолдолд тухайн гэмтсэн хэсгийг керн алдалтаар тооцож улмаар цооногийн өрөмдлөгийн ажлыг шаардлага хангалтгүй гүйцэтгэсэнд тооцон Захиалагч хүлээн



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

авахгүй /актлах/ бөгөөд баримт үйлдэнэ. Дээрх тохиолдолд Гүйцэтгэгч тал нь тухайн цооногийн өрөмдлөг, каротажийн ажлыг өөрийн зардлаар дахин (Redrill) гүйцэтгэнэ.

5.1.8. Өрөмдлөгөөс гарсан кернийн бохирдлыг бүрэн цэвэрлэн холбогдох бичиглэл, дээжлэлтийн ажлыг жигд, тогтвортой гүйцэтгэх боломжоор хангана.

5.1.9. Гүйцэтгэгч тал нь өрөмдлөгөөс гарсан кернийг цэвэрлэн зориулалтын хайрцаганд савлан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хээрийн геологийн оффист өөрийн унаагаар тээвэрлэлтийн эвдрэл, гэмтэлгүй, тогтсон хугацаанд хүргэж өгнө.

5.1.10. Гүйцэтгэгч нь цооногийн ханыг зориулалтын байгаль орчинд сөрөг нөлөөгүй материалаар, өрөмдлөгийн арга аргачлалын дагуу гүйцэтгэх бөгөөд цооногийг геофизик болон усны төвшингийн хэмжилт, мөн шаардлагатай тохиолдолд цооног тасалж open hole геофизикийн хэмжилт хийх нөхцлийг бүрэн гүйцэтгэх боломжоор хангана.

5.1.11. Цооногийн өрөмдлөгийн явцын тухай тэмдэглэлийг байнга хөтлөх бөгөөд цооногийн өрөмдлөгийн тайланг зохих загварын дагуу Захиалагч талд хүлээлгэн өгнө.

5.1.12. Хайгуулын ажлыг удирдаж нэгжийн сонгосон эсвэл нүүрсний давхрааст метан хий илэрсэн цооног бүрд нүүрсний давхраасын метан хийн агууламжийг тодорхойлох хэмжилтийн ажлыг гүйцэтгэх нөхцлийг хангаж ажиллана.

5.1.13. Метан хийн хэмжилт гүйцэтгэхтэй холбогдуулан гарах нэмэлт төлбөрийг харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

5.1.14. Цооногийн өрөмдлөгийн гүнийг цооногийн геофизикийн хэмжилтийн бүрэн (геофизикийн хэмжилтийн гэрээнд заасан штангтай болон open hole-ийн хэмжилтүүд) хэмжилтийн гүнээр тооцон, тухайн цооногийн өрөмдлөгийн ажлыг хүлээн авна.

5.1.15. Нүүрсний дээжийг чийг алдуулахгүй тулд ялтас дээр хэмжилт гүйцэтгэсний дараа хайрцагт савлаж нимгэн уутаар агаар, салхи нэвтрэхгүй байхаар битүүмжилнэ. Шаардгатай тохиолдолд чулуулгийн дээжийг мөн битүүмжлэнэ.

5.1.16. Цооног бүрд өрөмдлөгийн явцад илэрсэн гүний усны төвшинг тэмдэглэх бөгөөд өрөмдлөгийн ажил гүйцэтгэснээс хойш цооног бүрд гүний усны түвшинг тодорхой хугацааны дараа хэмжих, гүний усны статик төвшинг хэмжих нөхцөлийг бүрдүүлнэ. (24, 48 болон 72 цаг)

5.1.17. Хайгуулын ажил гүйцэтгэж буй талбайн тээврийн зам, талбайг засах, өргөтгөх, шинээр барих, сайжруулах, услах, арчлах ажлуудыг Захиалагчийн гаргасан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгч өөрийн зардлаар хийж гүйцэтгэнэ.

5.1.18. Өрөмдсөн цооног бүрд техникийн нөхөн сэргээлт болон уурхайн ахилтын хүрээнээс гадна талбайн цооногуудад хаягжуулалтын ажлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн байгаль орчныг нөхөн сэргээх дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ.

**5.2. ГҮЙЦЭТГЭГЧ НЬ ЦООНОГИЙН ГЕОФИЗИКИЙН АЖЛЫГ ДАРААХ БАЙДЛААР ГҮЙЦЭТГЭНЭ.**

5.2.1. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Тавантолгой ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нийт 123,000 тууш метр цооногийн геофизикийн хэмжилтийн ажлыг гэрээний Хавсралт №1-д заасан ажлын даалгаварын дагуу холбогдох горим, стандартын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.



НУУЦ CONFIDENTIAL
ИЛ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

5.2.2. Цооногийн геофизикийн ажил эхлэхээс өмнө Захиалагч талд ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, арга аргачлал, тоног төхөөрөмийн хүчин чадал, бэлэн байдал, нүний нөөцийн бүрдүүлэлт, туршлага, аюулгүй ажиллагаа хангах заавар зөвлөмж зэргийг багтаасан, танилцуулгыг гүйцэтгэгч талд танилцуулна.

5.2.3. Өрөмдсөн цооногт геофизикийн хэмжилтийг Dual density (short-spaced and long-spaced), Natural gamma, Acoustic-scanner-televiewer эсвэл dipmeter, dual resistivity PR, Caliper, Deviation (three arm), Sonic болон цооногийн тэнцвэржсэн усны төвшин тодорхойлох зэрэг аргачлалаар гүйцэтгэнэ.

5.2.4. Resistivity PR /Формацын цахилгаан эсэргүүцэл/ судалгааны үзүүлэлтээр цооногийн уст үеүдийг ялгана.

5.2.5. Гүйцэтгэгч нь хэмжилт хийх цооногийн дугаар, цооногийн солбилцлыг Захиалагчаас авч, өөрийн GPS багажаар тулган баталгаажуулж, хэмжилтийн ажлыг эхлүүлнэ.

5.2.6. Гүйцэтгэгч нь цооногт 7 аргачлалын хэмжилтийг бүрэн гүйцэтгэх бөгөөд штанггүй /open hole/ геофизикийн хэмжилтүүд нь хамгийн багадаа цооногийн нийт гүний 95%-д гүйцэтгэсэн цооногийг Захиалагч тал хүлээн авна. Геологийн хүндрэлээс шалтгаалж хэмжилт гүйцэтгэж чадаагүйг захиалагч талаас баталгаажуулсан тохиолдолд тухайн цооногийн /open hole/ хэмжилтийг гүйцэтгэсэнд тооцно.

5.2.7. Хээрийн ажлын үед цооногийн мэдээллийг хэмжилт хийснээс хойш 12 цагийн дотор нүүрсний давхраас, үе /өгөршсөн, исэлдсэн, коксжих зэрэг/, завсрын чулуулаг, цооногийн хазайлт /deviation/ зэргийг тодорхойлж, цооногийн анхан шатны логийн 1:200, нүүрсний давхраас, үеийг нарийвчлан 1:50 масштабаар тус тус 2 хувь хэвлэн, тоон форматын хамт Захиалагчийн тухайн ажлыг хариуцсан геологичид хүлээлгэн өгнө.

5.2.8. Цооногийн геофизикийн хэмжилтийн эцсийн боловсруулалтыг /bore hole geophysical log interpretation/ өрөмдлөгийн кернийн бичиглэлийн, геофизикийн хэмжилтийн, харьцуулсан багануудаар үүсгэн, өнгөтөөр 1 хувь 1:200 масштабаар хэвлэн, тоон форматын хамт хүлээлгэн өгөх бөгөөд Захиалагч талын загварын дагуу гүйцэтгэсэн тайлангийн хамт хүлээлгэн өгнө.

5.2.9. Цооногийн acoustic, resistivity PR, caliper, sonic-ийн хэмжилтийн үр дүн болон чулуулгийн геотехникийн туршилтын үр дүнг нэгтгэсэн цооногийн геотехникийн /bore hole geotechnical log interpretation/ боловсруулалтыг өнгөтөөр 1 хувь 1:200 масштабаар хэвлэн, тоон форматын хамт хүлээлгэн өгөх бөгөөд Захиалагч талын загварын дагуу гүйцэтгэсэн тайлангийн хамт хүлээлгэн өгнө.

## 5.3. ГҮЙЦЭТГЭГЧ НЬ НҮҮРСНИЙ ДЭЭЖИД ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХДЭЭ ДАРААХ БАЙДЛААР ГҮЙЦЭТГЭНЭ.

Нүүрсний дээж шинжилгээний ажил эхлэхээс өмнө Захиалагч талд ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, арга аргачлал, тоног төхөөрөмийн хүчин чадал, бэлэн байдал, нүний нөөцийн бүрдүүлэлт, туршлага, аюулгүй ажиллагаа хангах заавар зөвлөмж зэргийг багтаасан, танилцуулгыг гүйцэтгэгч талд танилцуулна.

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

**ДЭЭЖ ХҮЛЭЭН АВАХ, ТЭЭВЭРЛЭХ**

5.3.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Салбар уурхайгаас өөрийн тээврийн хэрэгслээр нүүрсний дээжийг (Хайгуулын ажлыг хариуцаж буй нэгжээс өгсөн зааврын дагуу) хүлээн авч, тээвэрлэнэ.

5.3.2. Захиалагчийн геологич нь тээвэрлэлтийн нөхцөлийг хянах, дээжийг хүлээлгэн өгөх зорилгоор дээжийг шаардлагатай тохиолдолд дагалдаж явна.

5.3.3. Захиалагч нь дээжийн дугаар, тоо, гүйцэтгэх шинжилгээг заасан захиалгын хуудсыг бөглөж, баталгаажуулах бөгөөд Гүйцэтгэгч тал дээжийн дугаарыг захиалгын хуудасны дагуу тулган шалгаж, тоо болон дугаарын зөрүү гарсан тохиолдолд 24 цагийн дотор Захиалагчийн холбогдох ажилтнуудад мэдэгдэж алдааг засна.

5.3.4. Захиалагч нь тээвэрлэн ирсэн нүүрсний дээжийг гүйцэтгэгч талтай тулгалт хийж хүлээлгэн өгнө.

**ДЭЭЖИЙН ШИНЖИЛГЭЭ**

5.3.5. Хайгуулын өрөмдлөгийн нүүрсний дээжүүдэд анхдагч дээжийн шинжилгээ, нарийвчилсан шинжилгээг үе шаттайгаар гүйцэтгэнэ.

5.3.6. Анхдагч дээжийн шинжилгээ гэрээний Хавсралт №1-ийн хүснэгт №1/-д өрөмдлөгийн нүүрсний 20500 /хорин мянга таван зуу/ хүртэлх дээжид, Дээж бэлтгэл, Нийт чийг, Аналитик чийг, Үнслэг, Дэгдэмхий бодисын гарц, Нийт хүхэр, Илчлэг, Чөлөөт хөөлтийн зэрэг, Барьцалдалт Ж-индекс, Харьцангуй нягт тодорхойлох зэрэг шинжилгээг гүйцэтгэх бөгөөд шинжилгээ хийгдэх дээжийн тоо хэмжээ нь хайгуулын өрөмдлөгөөр оготлогдсон нүүрсний үе давхаргын тоо, түүний зузаанаас хамаарч дээжийн тоо хэмжээ хэлбэлзэж болно.

5.3.7. Анхан шатны баяжуулалтын туршилт шинжилгээг Хавсралт №1-ийн схем №1, хүснэгт №2, хүснэгт №3, хүснэгт №4/-ийн дагуу Анхдагч дээжийн шинжилгээний үр дүнгээс хамаарч Захиалагч тал анхан шатны баяжуулалтын туршилт гүйцэтгэх дээжийг багцлан сонгох бөгөөд 240 ширхэг хүртэлх дээжийг Захиалагч тал баталгаажуулан хүргүүлэх бөгөөд дээжийн тоо хэмжээ хэлбэлзэж болно.

5.3.8. Гүн шатны баяжуулалтын туршилт шинжилгээг гэрээний Хавсралт №1-ийн схем №2/-ийн дагуу анхдагч дээжийн шинжилгээний үр дүнгээс хамаарч Захиалагч тал гүйцэтгэх дээжийг багцлан сонгох бөгөөд 30 хүртэлх дээжийг Захиалагч тал баталгаажуулан хүргүүлэх бөгөөд дээжийн тоо хэмжээ хэлбэлзэж болно.

5.3.9. Нарийвчилсан шинжилгээг гэрээний Хавсралт №1-ийн хүснэгт №5/-д заасан стандартын дагуу Хавсралт №3-д заасан дээжид шинжилгээг гүйцэтгэх бөгөөд хайгуулын өрөмдлөгөөр оготлогдсон нүүрсний үе давхаргын тоо, түүний зузаанаас хамаарч нарийвчилсан дээж хоорондын тоо хэмжээ хэлбэлзэж болно.

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

Талуудын гарын үсэг

**ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН ТАЙЛАГНАХ**

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

5.3.10. Гүйцэтгэгч нь нүүрсний анхдагч дээжийн шинжилгээг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш дээж тутмыг ажлын 8 /найм/ хоногт багтаан Захиалагчийн хүссэн загварт оруулан цахим хэлбэрээр хүргүүлнэ. Баталгаажуулсан байдлаар тухайн сарын шинжилгээний үр дүнг дараагийн сарын эхний ажлын 10 хоногт багтаан Захиалагчид цаасан хүлээлгэн өгнө.

5.3.11. Гүйцэтгэгч нь нүүрсний баяжуулалтын бүрэн хэмжээний туршилт шинжилгээний дээжийн үр дүнг дээжийг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш ажлын 20 /хорь/ хоногт багтаан Захиалагчийн хүссэн загварт оруулан цахим хэлбэрээр хүргүүлнэ.

5.3.12. Захиалагч нь ажлын шаардлагаар яаралтай шинжилгээнд оруулах анхдагч дээжийг Гүйцэтгэгч талд хүлээлгэн өгч болно. Энэ тохиолдолд яаралтай дээжийг хүлээлгэн өгснөөс хойш 25 хүртэлх дээжийг 24 цагийн дотор хариуцсан геологичид болон захиалгын хуудсанд үр дүнг хүлээн авагчаар бөглөсөн электрон шуудангийн хаягаар илгээнэ.

5.3.13. Анхдагч нүүрсний дээжийн шинжилгээний үр дүнг as received /анхдагч/; air dried /агаарын хуурай/; dry /хуурай/; dry and ash-free /хуурай, үнсгүй/ төлөвүүдээр илэрхийлсэн байна. Гүйцэтгэгч нь нийт шинжилгээний хариуг гэрээний хугацаа дууссан өдрөөс 5 жилийн хугацаанд хадгална.

5.3.14. Шинжилгээний үр дүнг доорх хаягуудаар илгээнэ.

1. Khishigbaatar.kh@erdenestt.mn
2. Tsendmaa.b@erdenestt.mn
3. Exploration@erdenestt.mn

5.3.15. Шинжилгээний үр дүнг илгээх хаягуудад Захиалагч албан байдлаар Гүйцэтгэгч талд мэдэгдэж, хаягийн өөрчлөлтүүдийг хийнэ.

5.3.16. Гүйцэтгэгч нь гэрээт үйлчилгээг дууссаны дараа Захиалагч талын загварын дагуу нэгдсэн тайланг боловсруулан бүх шатны шинжилгээний үр дүнг CD-д хуулсан, тамга тэмдгээр баталгаажуулж хүлээлгэн өгнө.

**ДЭЭЖ ХАДГАЛАЛТ, УСТГАЛ**

5.3.17. Гүйцэтгэгч нь нүүрсний дээж хадгалах хөргөлттэй контейнер эсвэл зориулалтын дагуу температурыг нь тохируулж болдог дээж хадгалах өрөөтэй байна.

5.3.18. Анхдагч дээжийг хүлээлгэн өгснөөс эхлэн бүх дээжийг дараагийн шатны туршилт шинжилгээ хийгдэж дуусах хүртэл хугацаанд нүүрсний дээжийг чанарын өөрчлөлт орохгүй, холбогдох стандартын дагуу хадгална.

5.3.19. Захиалагч талаас сар тутамд дээж хадгалалтыг стандартын дагуу байгаа эсэхийг баталгаажуулна.

5.3.20. Хүлээн авч, захиалгын дагуу зохих шинжилгээг гүйцэтгэж, дууссан дээжийн үлдэгдэл хэсгийг үйлчилгээ үзүүлэгч 3 /гурав/ жилийн хугацаанд зохих стандартын дагуу зориулалтын дээж хадгалах байранд өөрийн зардлаар хадгална.

5.3.21. Гэрээний 5.3.27-д заасан хугацаа дуусахад устгах зөвшөөрлийг Захиалагчаас авсны дараа Гүйцэтгэгч тал өөрийн зардлаар устгана.

ХЭЗГ №01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

5.3.22. Гэрээний 5.3.27-д заасан хугацаа дуусахад Захиалагч дээжийг устгахгүй гэж шийдвэл өөрийн зардлаар Гүйцэтгэгч талын хадгалах байрнаас авна.

**5.4. ГҮЙЦЭТГЭГЧ НЬ ЧУЛУУЛАГ БОЛОН ХӨРСНИЙ ДЭЭЖИД ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫГ ДАРААХ БАЙДЛААР ГҮЙЦЭТГЭНЭ.**

Чулуулгийн дээж шинжилгээний ажил эхлэхээс өмнө Захиалагч талд ажлыг гүйцэтгэх төлөвлөгөө, арга аргачлал, тоног төхөөрөмийн хүчин чадал, бэлэн байдал, нүний нөөцийн бүрдүүлэлт, туршлага, аюулгүй ажиллагаа хангах заавар зөвлөмж зэргийг багтаасан, танилцуулгыг гүйцэтгэгч талд танилцуулна.

**ДЭЭЖ ХҮЛЭЭН АВАХ, ТЭЭВЭРЛЭХ**

5.4.1. Гүйцэтгэгч нь Захиалагчийн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Салбар уурхайгаас чулуулгийн дээжийг зохих стандартын дагуу эвдэрч, бутрах, чийг алдахаас урьдчилан сэргийлж, зориулалтын битүүмжлэлтэй, хайрцагт савлаж, өөрийн тээврийн хэрэгслээр (Хайгуулын ажлыг хариуцаж буй нэгжээс өгсөн зааврын дагуу) хүлээн авч, тээвэрлэнэ.

5.4.2. Захиалагчийн геологич нь тээвэрлэлтийн нөхцөлийг хянах, дээжийг хүлээлгэн өгөх зорилгоор дээжийг шаардлагатай тохиолдолд дагалдаж явна.

5.4.3. Гүйцэтгэгч нь чулуулгийн дээжийг захиалагч талтай тулгалт хийж хүлээж авна.

5.4.4. Захиалагч нь дээжийн дугаар, тоо, гүйцэтгэх шинжилгээг заасан захиалгын хуудсыг бөглөж, баталгаажуулах бөгөөд Гүйцэтгэгч тал дээжийн дугаарыг захиалгын хуудасны дагуу тулган шалгаж, тоо болон дугаарын зөрүү гарсан тохиолдолд 24 цагийн дотор Захиалагчийн холбогдох ажилтнуудад мэдэгдэж алдааг засна.

**ДЭЭЖИЙН ШИНЖИЛГЭЭ**

5.4.5. Өрөмдлөгийн ажлаар гарч ирсэн чулуулгийн болон хөрсний дээжүүдэд физик механикийн шинж чанар тодорхойлох туршилт шинжилгээг стандартын дагуу гүйцэтгэж үр дүнг Захиалагчид гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

5.4.6. Чулуулгийн дээж шинжилгээг /Хавсралт №1-ийн хүснэгт №6/-д өрөмдлөгийн чулуулгийн 6210 хүртэлх дээжид, Дээж бэлтгэл, чийгшил, нягт, нэг тэнхлэгийн дагуу шахалтын бат бөхийн хязгаар, гурван тэнхлэгийн дагуух шахалтын бат бөхийн хязгаар, суналтын бат бөхийн хязгаар, шилжилтийн бат бөхийн хязгаар, хувийн жин, юнгийн модуль, пауссоны коэффифиент, дотоод үрэлтийн өнцөг, барьцалдалтын хүч тодорхойлох зэрэг шинжилгээ, туршилтыг гүйцэтгэх бөгөөд шинжилгээ хийгдэх дээжийн тоо хэмжээ нь өрөмдлөгөөр огтлогдсон чулуулгийн нэр, төрөл, түүний зузаанаас хамаарч дээжийн тоо хэмжээ хэлбэлзэж болно.

5.4.7. Геотехникийн дээж шинжилгээг ///Хавсралт №1-ийн хүснэгт №6/-д өрөмдлөгийн чулуулгийн 1400 хүртэлх дээжид, Дээж бэлтгэл, чийгшил, нягт, нэг тэнхлэгийн дагуу шахалтын бат бөхийн хязгаар, гурван тэнхлэгийн дагуух шахалтын бат бөхийн хязгаар, суналтын бат бөхийн хязгаар,



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

хязгаар, шилжилтийн бат бөхийн хязгаар, хувийн жин, юнгийн модуль, пауссоны коэффифиент, дотоод үрэлтийн өнцөг, барьцалдалтын хүч тодорхойлох зэрэг шинжилгээ, туршилтыг гүйцэтгэх бөгөөд шинжилгээ хийгдэх дээжийн тоо хэмжээ нь өрөмдлөгөөр оглогдсон чулуулгийн нэр, төрөл, түүний зузаанаас хамаарч дээжийн тоо хэмжээ хэлбэлзэж болно.

5.4.8. Хөрсний дээж шинжилгээг /Хавсралт №1-ийн хүснэгт №7/-д өрөмдлөгийн хөрсний 1000 хүртэлх дээжид, Дээж бэлтгэл, чийг болон нягтыг тодорхойлох, шахалтад үзүүлэх бат бэхийн чанар, суналтад үзүүлэх бат бэх чанар, эзлэхүүн жин, барьцалдалд /бутрамтгай/ чанар, бутралын маркаар шилжүүлсэн чулуулгийн бат бэх чанар, дотоод үрэлтийн өнцөг, хөрсний физик шинжилгээ, туршилтыг гүйцэтгэх бөгөөд шинжилгээ хийгдэх дээжийн тоо хэмжээ нь өрөмдлөгөөр оглогдсон чулуулгийн нэр, төрөл, түүний зузаанаас хамаарч дээжийн тоо хэмжээ хэлбэлзэж болно.

**ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН ТАЙЛАГНАХ**

5.4.9. Гүйцэтгэгч тал нь дээжийн шинжилгээг хүлээлгэн өгсөн өдрөөс хойш тухайн дээж тутмыг ажлын 15 /арав/ хоногт багтаан Захиалагчийн хүссэн загварт оруулан цахим хэлбэрээр хүргүүлнэ. Баталгаажуулсан байдлаар тухайн сарын шинжилгээний үр дүнг дараагийн сарын эхний ажлын 5 хоногт багтаан Захиалагчид хүлээлгэн өгнө.

5.4.10. Гүйцэтгэгч нь нийт шинжилгээний хариуг гэрээний хугацаа дууссан өдрөөс 5 жилийн хугацаанд хадгална.

5.4.11. Шинжилгээний үр дүнг доорх хаягуудаар илгээнэ.

1. Khishigbaatar.kh@erdenestt.mn
2. Tegshjantsan.g@erdenestt.mn
3. Erdene.E@erdenestt.mn
4. Jadamba.e@erdenestt.mn
5. Ganjargal.m@erdenestt.mn
6. Exploration@erdenestt.mn

5.4.12. Шинжилгээний үр дүнг илгээх хаягуудад Захиалагч албан байдлаар Гүйцэтгэгч талд мэдэгдэж, хаягийн өөрчлөлтүүдийг хийнэ.

5.4.13. Гүйцэтгэгч нь гэрээт үйлчилгээг дууссаны дараа Захиалагч талын загварын дагуу нэгдсэн тайланг боловсруулан бүх шатны шинжилгээний үр дүнг CD-д хуулсан, тамга тэмдгээр баталгаажуулж хүлээлгэн өгнө.

**ДЭЭЖ ХАДГАЛАЛТ, УСТГАЛ**

5.4.14. Гүйцэтгэгч нь дээж хадгалах хэрэглэттэй контейнер эсвэл зориулалтын дагуу температурыг нь тохируулж болдог дээж хадгалах өрөөтэй байна.

5.4.15. Анхдагч дээжийг хүлээлгэн өгснөөс эхлэн бүх дээжийг дараагийн шатны туршилт шинжилгээ хийгдэж дуусах хүртэл хугацаанд дээжийн чанарын өөрчлөлт орохгүй, стандартын дагуу хэрэгтэй орчинд хадгална.

НУУЦ
ИЛ БОЛСОН
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

## 5.5. ГҮЙЦЭТГЭГЧ НЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААР.

ИЛ БОЛСОН

5.5.1. Гүйцэтгэгч нь байгаль орчин хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу өөрийн компанийн тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөөг Захиалагчаар хянуулан батлуулж, биелэлтийг Захиалагчид улирал болон сар бүр тайлагнана.

5.5.2. Хайгуулын үйл ажиллагаанаас үүссэн хий, хатуу, шингэн хог хаягдлыг Монгол улсын хууль, журам, стандарт болон Захиалагчийн дотоод журмын дагуу төвлөрүүлэх, зайлуулах, бохирдсон хөрс саармагжуулах талбай болон хог хаягдлын байгууламж барьж ашиглах, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх цогц арга хэмжээг тусгасан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан Захиалагчаар хянуулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллана. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэн саармагжуулах, шатаах зориулалтын төхөөрөмж ашиглана. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

5.5.3. Үйл ажиллагаанд ашиглах ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг био задралд хурдан ордог, байгаль орчинд үзүүлэх хор аюул багатай бүтээгдэхүүнээр орлуулж ашиглана.

5.5.4. Үйл ажиллагааны явцад эвдэрсэн, доройтсон, бохирдсон газар болон хог хаягдлын түр цэгт техникийн нөхөн сэргээлт хийн бохирдлыг арилгаж, ажил дуусгавар болоход Захиалагчид хүлээлгэж өгнө.

5.5.5. Хайгуулын ажлын тээврийн технологийн дотоод замаас үүсэх тоосжилтын түвшнийг шинжлэх ухааны аргаар хэмжих, дэвшилтэт технологи ашиглан тоос бууруулах төлөвлөгөө боловсруулан, захиалагчаар батлуулан хэрэгжилтийг сар бүр тайлагнаж ажиллана.

5.5.6. Ажлыг гүйцэтгэх үедээ нийтийн зам талбай, байгууламжид чулуу, шороо, барилгын материалын үлдэгдэл зэрэг хог хаягдал хаяхгүй цэвэр цэмцгэр байлгах, орчин тойрныг бохирдуулахгүй, хаягдсан хог материалыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэж байна.

5.5.7. Гүйцэтгэгч нь хайгуулын өрөмдлөгийн ажлын технологийн хэрэгцээнд ашиглах зорилгоор шинээр худаг өрөмдөж гаргах, холбогдох тоноглолыг хийж, пасспортжуулах ажлыг өөрийн зардлаар хийж холбогдох байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулан уулын ажлын хэвийн нөхцөлийг хангаж ажиллах бөгөөд энэхүү гэрээний хугацаа дуусах үед Захиалагчид бүрэн хүлээлгэн өгнө.

5.5.8. Гүйцэтгэгч тал нь хайгуулын талбайн тоосжилтийн төвшинг байгаль цаг агаар уурын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлөөс үүссэнээс бусад үед Монгол улсын холбогдох стандартын төвшинд барих үүрэгтэй. Хэрэв стандартын түвшинөөс хэтэрсэн тохиолдолд хайгуулын үйл ажиллагаа захиалагч тал зогсоох эрхтэй бөгөөд тоосжилтоос шалтгаалан зогссон хариуцлагыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

5.5.9. Гүйцэтгэгчид орон нутгаас ирсэн санал, гомдлын мөрөөр даруй хариу арга хэмжээ авч ажиллах ба зөрчлийг арилгасан тайланг тухай бүр тайлагнаж ажиллана.

5.5.10. Гүйцэтгэгч нь Нийгмийн хариуцлагын хүрээнд Захиалагчийн хэрэгжүүлж буй "Сая тонн-сая мод" хөтөлбөрийг дэмжин нийт ажлын 1 /нэг/ хувьтай тэнцэх хэмжээний зардлыг хариуцан мод тарих, суулгах, ургуулах, арчлах ажлыг гүйцэтгэнэ.

ИЛ БОЛСОН

## ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Гүйцэтгэгч нь Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт болон ажил гүйцэтгэх үед хэрэглэгдэх стандарт, дүрэм, журам нормуудыг чандлан мөрдөж ажиллах үүрэгтэй.

6.2. "Хамтарсан түншлэл"-ийн компаниуд нь гэрээний дагуу ажил үүргээ гүйцэтгэж чадаагүй, гүйцэтгэсэн ажил нь стандарт шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулах бичиг баримтанд заасан түүнд дүйцэхүйц компаниар сольж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

6.3. Өрөмлөгийн ажлыг гэрээний 5.1.4-д заасан тоног төхөөрөмжөөр гүйцэтгэх ба хэрвээ тоног төхөөрөмж эвдэрч, гэмтсэн тохиолдолд уг тоног төхөөрөмжийг тухайн ажлын тендерийн материалд ирүүлсэн тоног төхөөрөмжтэй дүйцэхүйц тоног төхөөрөмжөөр яаралтай сольж гүйцэтгэнэ. Хэрвээ тоног төхөөрөмжийн тоо хэмжээ дутсан, эвдэрсэн болон аливаа саатал гарсаны улмаас Гэрээний дагуу гүйцэтгэх Ажил удааширсан, зогссон, доголдсон тохиолдолд үүнээс үүдэн гарах хохирол, зардлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

6.4. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, үүргийг хангаж ажиллах бөгөөд гэрээнд заасан ажлыг гүйцэтгэж, гэрээний явцад гарсан зөрчил, алдааг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

6.5. Хайрцагласан дээжүүдийг анкорт байрлуулах, фото зураг авахад зориулан шавар, өрөмдлөгийн шингэнээс цэвэрлэн угаах ажлыг гүйцэтгэх 4-оос доошгүй туслах ажилтанг Захиалагч талын хүсэлтээр Гүйцэтгэгч талаас гаргаж ажиллуулж болно.

6.6. Цооногийн өрөмдлөгийн хайрцагласан дээжийг анкорт өрөмдлөгийн талбайгаас өдөр бүр тээвэрлэн авчрах бөгөөд дээжлэлтийн дараа Захиалагч компанийн заасан дээж хадгалах талбайд буулгана. Тээвэрлэлтийн үеийн кернийн гэмтэл, бүрэн бүтэн байдлыг Гүйцэтгэгч тал хангаж ажиллана.

6.7. Өрөмдлөгийн техник, тоног төхөөрөмж, машин нь ямар нэг эвдрэл гэмтэлгүй, ажлын тасралтгүй үйл ажиллагааг Гүйцэтгэгч тал бүрэн найдвартай хангах бөгөөд хүн тээвэрлэх суудлын машин нь жолооны зөв хүрдтэй байна.

6.8. Захиалагч компанийн байгаль орчин хариуцсан ажилтны заавар, хяналтын дагуу өрөмдлөгийн ажлыг байгаль орчинд аль болох хор нөлөө багатайгаар гүйцэтгэнэ.

6.9. Өдөр тутмын болон 7 хоногийн өрөмдлөгийн ажлын тайланг зохих форматын дагуу тогтмол цахимаар хүлээлгэн өгөх ба хайгуулын ажил дууссаны дараа нэгтгэсэн ажлын тайланг боловсруулж захиалагчийн өгсөн загварын дагуу боловсруулж захиалагч талд хүлээлгэн өгнө.

ЭТТ ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

6.10. Гүйцэтгэгч нь өрөмдсөн цооног бүр дээр нөхөн сэргээлтийн ажлыг Захиалагчийн байгаль орчны нөхөн сэргээх дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ. Холбогдох загварын дагуу хаягжуулалт болон техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэнэ. (өрөмдсөн огноо, гүн болон дугаар гэх мэт цооногийн холбогдолтой мэдээллийг оруулах, цооног тус бүрийг цооног эхлэхээс өмнө, өрөмдлөгийн дараа, техникийн нөхөн сэргээлт хийсэний дараа тус бүр зургаар баталгаажуулна.)

6.11. Нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж, тайланг боловсруулан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын засаг даргын газраас томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч Захиалагч талд холбогдох материал, нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан тухай актыг эх хувиар хүлээлгэн өгнө.

6.12. Гүйцэтгэгч тал нь өрөмдлөгийн ажил эхлэхээс өмнө Өмнөговь аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газартай ус ашиглах гэрээ болон Цогтцэций сумын тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулах ба ажил дууссаны дараа гэрээг дүгнэж баримтаа ирүүлнэ.

6.13. Гүйцэтгэгч нь нийт өрөмдсөн цооногийн 10 хүртэлх хувьд шаардлагатай тохиолдолд чиглэл (Orientation) өрөмдлөгийн ажлыг захиалагчийн өгсөн заавын дагуу гүйцэтгэнэ.

6.14. Өрөмдлөгийн үйл ажиллагааг хянах, шаардлага тавьж буй Захиалагч талын геологичийн өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох өөрчлөлт, аливаа алдаа дутагдлыг арилгах, сайжруулах арга хэмжээг авч ажиллана.

6.15. Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн явцад шаардлагатай усны хэрэгцээг өөрсдийн зардлаар гаргана. /худаг болон бусад эх үүсвэрээс/

6.16. Хайгуулын ажилд ажиллах техникүүд дээр нэгдсэн нэг тэмдэглэгээг байрлуулж жигдэрсэн байна. Байрлуулах тэмдэглэгээний нэгдсэн загварыг Захиалагч батална.

6.17. Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн болон туслах техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг гэрээнд заасан хувиас доошгүй бүрэн хангаж ажиллана.

6.18. Гүйцэтгэгч нь цооногийн геофизикийн хэмжилтийн орчин үеийн өндөр нарийвчлалтай багаж төхөөрөмжтэй байх үүрэгтэй бөгөөд цооногийн хэмжилт, боловсруулалт тайлалтыг зориулалтын мэргэжлийн программ дээр боловсруулах үүрэгтэй.

6.19. Цооногийн геофизикийн /каротаж/ ажилд мэргэжлийн хяналтын ерөнхий газар, цөмийн болон цацрагийн хяналтын газрын зөвшөөрөлтэй байх бөгөөд багадаа 100 мкю дээш хүчин чадалтай үүсгүүртэй байна.

6.20. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх зориулалтын бүрэн тоноглогдсон 3-аас доошгүй машинтай байх бөгөөд тухайн машин нь dual density, gamma, dipmeter, resistivity PR, caliper, deviation, sonic, усны түвшин хэмжигч зэрэг судалгаанд шаардагдах тоног төхөөрөмж, шаардлагатай сэлбэг, нөөц багажаар бүрэн хангагдсан байна.

6.21. Хэрвээ тоног төхөөрөмжийн тоо хэмжээ дутсан, эвдэрсэн болон аливаа саатал гарсаны улмаас Гэрээний дагуу гүйцэтгэх ажил удааширсан, зогссон, доголдсон тохиолдолд үүнээс үүдэн гарах хохирол, зардлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

6.22. Цооногийн геофизикийн хэмжилттэй холбоотойгоор ажлыг эхлүүлэхээс өмнө хийгдэх ажлын дараалал, арга аргачлал зэргийг Захиалагчийн геологичдод мэдээллэх, сургалтад (танилцуулга) хамруулах бөгөөд хоёр тал харилцан тохирох замаар арга, аргачлалыг өөрчлөн, сайжруулах боломжтой байна.

6.23. Багаж, тоног төхөөрөмжийн үнэн зөв, найдвартай ажиллагааг хангах үүднээс тулгуур/эталон цооногийг ашиглан долоо хоногт 1-ээс доошгүй удаа хянаж байх ба Захиалагчийн хариуцсан геологичийн хяналтан доор хийж, хэмжилтийн анхдагч утгыг Захиалагч талд шууд хүргүүлнэ.

6.24. Цооногийн геофизикийн хэмжилтийн ажилд шаардлагатай цацраг идэвхит үүсгүүр бүхий багажууд нь мэргэжлийн хяналтын ерөнхий газар, цөмийн хяналтын болон цацрагийн хяналтын газрын зохих зөвшөөрөлтэй байх ба Гүйцэтгэгчийн геофизикч нар нь холбогдох аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдсан байна.

6.25. Ажлын даалгаварт заасан шаардлагыг хангасан ур чадвар, боловсрол, туршлага бүхий 6-аас доошгүй геофизикч байх ба өдөр, шөнийн ээлжинд 2-оос доошгүй геофизикчтэй байна.

6.26. Цооногийн геофизикийн хэмжилт хийгдэж дуусаад цооног бүрд цооногийн усны түвшингийн өөрчлөлтийг Захиалагч талын тогтоосон хуваарийн дагуу хэмжиж, үр дүнг Захиалагч талд хүлээлгэн өгнө.

6.27. Гүйцэтгэгч нь далд уурхайн геотехникийн чиглэлээр мэргэшсэн гадаад зөвлөхтэй дотоодын багтай байна.

6.28. Гүйцэтгэгч нь нүүрс болон чулуулгийн шинжилгээний аргачлалыг зөв тодорхойлж, шинжилгээний гарах хариу, үр дүн нь цаашдын үйл ажиллагаанд хэр тохиромжтой эсэхийг шийдвэрлэхэд Захиалагч талд дэмжлэг, зөвлөгөө үзүүлнэ.

6.29. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг Ажлын даалгавар /Хавсралт №1/, холбогдох стандарт, дүрэм, журамд нийцүүлэн шинжилгээ туршилтын ажлыг гүйцэтгэх үүрэгтэй.

6.30. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу хийгдэх нүүрс болон чулуулгийн шинжилгээ туршилтын талаар танилцуулах, сургалтад хамруулах, шинжилгээ туршилтын дараалал, аргачлалыг нарийвчлан сайжруулахад Захиалагчтай хамтран ажиллах үүрэгтэй.

6.31. Гүйцэтгэгч нь гэрээний хэрэгжилтийн хугацаанд нүүрс болон чулуулгийн шинжилгээний аргачлал, ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн явц зэргийг Захиалагчид танилцуулж, хянуулж ажиллана.

6.32. Гүйцэтгэгч нь үе шат бүрийн шинжилгээний үр дүнг нүүрс болон чулуулгийн шинжилгээний техникийн тодорхойлолттой, шинжилгээний төрөл, MNS/ISO, GB/ISO, ISO, ASTM/ISO стандартын дагуу хийж гүйцэтгэн Захиалагчид үр дүнг цаг алдалгүй хүлээлгэн өгнө.

6.33. Гүйцэтгэгч нь нүүрс болон чулуулгийн шинжилгээний үр дүнг өдөр, 7 хоног болон сар тутам захиалагчийн хүссэн загварт оруулан файл болон цаасаар илгээх ба шаардлагатай тохиолдолд англи хэл дээр хүргүүлнэ.

6.34. Гүйцэтгэгчийн лабораторийн ажилтан, ажиллагсад нь мэргэжлийн түвшний тодорхой шаардлагыг хангасан, ажлын туршлагатай, мэргэшсэн ажилтны хангалттай нөөцтэй, боловсон хүчнээ бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

талаар олон улсын жишигт нийцсэн сургалтын хөтөлбөртэй, дотоод хяналтын системтэй, түүнийгээ хэрэгжүүлж хэвшсэн байх шаардлагатай.

6.35.Гүйцэтгэгч нь шаардлагатай тохиолдолд Захиалагчийн зөвшөөрлийг үндэслэн зарим шинжилгээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлж болно.

6.36.Гүйцэтгэгч нь стандартын шаардлага хангаагүйгээс гүйцэтгэсэн ажил үр дүнгүй болж Захиалагчид хохирол учирсан бол хохирлыг бүрэн хариуцна.

6.37.Гүйцэтгэгч нь нүүрсний анхдагч болон баяжуулсан дээжийн шинжилгээнд хамрагдсан нийт дээж болон чулуулаг, геотехникийн болон хөрсний шинжилгээ, туршилт гүйцэтгэсэн нийт дээжийн дөрөв /4%/ хүртэлх хувьд тус бүр хөндлөнгийн хяналтын лабораториор хяналтын шинжилгээг өөрийн зардлаар гүйцэтгүүлнэ. Хөндлөнгийн хяналтын лаборатори нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, үйлчилгээ үзүүлэгч талтай адил түвшний чадвар бүхий лаборатори байх бөгөөд Захиалагч тал хөндлөнгийн лабораторийг сонгоно.

6.38.Хөндлөнгийн дээж шинжилгээний үр дүн нь лаборатори хоорондын зөвшөөрөгдөх стандарт зөрүүнээс их гарсан тохиолдолд түүнийг төлөөлж буй анхдагч дээжийн төлбөрийг Захиалагчаас нэхэмжлэх эрхгүй.

6.39.Хөндлөнгийн дээж шинжилгээний үр дүнг Гүйцэтгэгч тал хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд 3 дагч лабораторид шинжилгээг гүйцэтгүүлж үр дүнгээр маргааныг шийдвэрлэх бөгөөд зардлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

6.40.Захиалагчаас ирүүлсэн мэдээлэл болон гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн шинжилгээний үр дүн болон холбогдох мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэг хүлээнэ. Энэхүү үүргээ санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлээр зөрчсөн тохиолдолд Захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна.

6.41.Гүйцэтгэгч болон Захиалагчийн ажилтнууд аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд тавьж ажиллах өндөр ухамсартай, харилцааны соёлтой байхаас гадна Захиалагчийн хяналт тавих эрх бүхий ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах мэргэжлийн болон зан суртахууны өндөр чадвартай байна.

6.42.Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, дамжуулахыг хориглох бөгөөд гэрээний үүргээ биелүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад туслан гүйцэтгэгчээр материал ирүүлсэн болон бусад туслан гүйцэтгэгч ажиллуулахдаа Захиалагчид урьдчилан бичгээр мэдэгдэж, захиалагчаас бичгээр /нэр, оролцооны хувь хэмжээ, чиг үүрэг/ зөвшөөрөл авч, туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хувийг Захиалагчид албан ёсоор ирүүлнэ.

6.43.Захиалагчийн Салбарын баталсан хууль тогтоомжид нийцсэн дүрэм, журам, горим, заавар болон бусад шаардлагатай баримт бичгийг заавал дагаж мөрдөнө.

6.44.Энэхүү гэрээний 5 дугаар зүйлд заасан Гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлыг бүрэн биелүүлж ажиллана.

6.45.Хайгуулын талбайд ажиллах гүйцэтгэгчийн үндсэн болон туслах техник, тоног төхөөрөмжүүдийг бүрэн үзлэгт хамруулж холбогдох дүрэм, журам, горим, зааврын дагуу уурхайн бүст ажиллуулах зөвшөөрөл авч ажиллана.

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

6.46.Технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдол гарсан тохиолдолд Захиалагчид мэдэгдсэний дагуу заасан хугацаанд арга хэмжээ авч, үр дүнг Захиалагчид танилцуулж, зөвшөөрөл авсны дараагаар хэвийн үйл ажиллагааг эхлүүлнэ.

ИЛ БОЛСОН

6.47.Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх шаардлагатай жолоочийн хариуцлагын, хүнд машин механизмын, авто тээврийн хэрэгслийн зэрэг холбогдох бүхий л даатгалын гэрээг хийлгэсэн байна.

6.48.Ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдлын талаар Захиалагчаас мэдэгдсэний дагуу нэн даруй арга хэмжээ авч ажлыг хэвийн хэмжээнд оруулна.

6.49.Гүйцэтгэгч нь Захиалагчийн инженер техникийн ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй байгаль орчны ажилтнуудыг ажлын талбайд саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтнуудын холбогдох дүрэм журам, горим, зааварт нийцүүлэн тавьсан шаардлагыг биелүүлнэ.

6.50.Энэхүү гэрээнд заасны дагуу ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор Захиалагчийн эрх бүхий инженер техникийн ажилтнуудтай хамтран ажиллана.

6.51.Гүйцэтгэгч хийж гүйцэтгэсэн ажлын төлбөрийг сар бүрийн гүйцэтгэлээр гэрээнд заасан хугацаанд нэхэмжлэх бөгөөд дутуу захиалсан ажлын хөлсийг Захилагачаас нэхэмжлэх эрхгүй.

6.52.Гүйцэтгэгч болон тэдгээрийн ажилтан нь энэхүү гэрээ, түүнтэй холбоотой ажил, үйлчилгээ болон Захиалагчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээ, мэдээллийг гэрээний хэрэгжилтийн явцад болон гэрээг хэрэгжиж дууссаныг үл харгалзан бусдад задруулахыг хориглоно.

6.53.Гэрээнд заасан хайгуулын ажлыг саадгүй гүйцэтгэхэд шаардлагатай техник тоног төхөөрөмж, байр сууц, байгууламжийг тээвэрлэх, байршуулах, угсрах график төлөвлөгөөг боловсруулж Захиалагчид танилцуулна.

6.54.Ажлыг гүйцэтгэхдээ галын аюулгүй байдал, чанар, эрүүл мэндийн шаардлага хангасан материал ашиглана.

6.55.Ажил гүйцэтгэх явцад аюулгүй ажиллагааг хангаагүй, гүйцэтгэж буй ажилдаа болгоомжгүй, хайнга хандсан, холбогдох стандарт, журмыг мөрдөөгүйн улмаас Захиалагчийн болон гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд холбогдон гарах бүхий л зардал /хууль зүйн болон үйл ажиллагааны, бусад/-ыг бүрэн хариуцаж, гарсан хохирол зардал, хариуцлагыг бүрэн хүлээн, барагдуулна.

6.56.Гүйцэтгэгч шаардлагатай тохиолдолд Захиалагчийн радио станцын долгионд таарах радио станцаар хангагдсан байна.

6.57.Түншлэлийг төлөөлөх эрх бүхий этгээд нь гэрээний гүйцэтгэлтэй холбоотойгоор Захиалагчтай харилцаж, түншлэлийг төлөөлөх, зааварчилгаа авах, хайгуулын ажлын гүйцэтгэлийн тооцоог нийлэх, Захиалагчаас шилжүүлсэн ажлын төлбөрийг өөрийн дансанд хүлээн авч Түншлэлийн гишүүдэд шилжүүлэх үүрэгтэй.

6.58.Гүйцэтгэгч нь геологийн бичиглэл, дээжлэлт гүйцэтгэх зориулалт бүхий дулаалга, халаагуур, эйр кондишен, шалтай (тоос босохооргүй), битүүмж сайтай, аюулгүй байдлыг хангасан, шаардлага хангасан гэрэлтүүлэг болон зориулалтын урт кернийн тавиур ширээгээр тоноглосон 1 ширхэг зөөврийн

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

байр (25 метрийн урттай, 10 метрийн өргөнтэй, 2 талдаа хаалгатай, байгалийн гэрэл нэвтрэх цонхнуудтай байна) хангана. Зөөврийн байранд байрлуулах дээжийн бичиглэл гүйцэтгэх ширээний бүтэц нь зэрэгцээ 3 шугамтай, нэг шугамын урт 17 м-ээс багагүй урттай, хайрцагтай дээж саадгүй явуулах рольктой, Бичиглэл гүйцэтгэх ширээний дээр гүйдэг замтай лед гэрэлтэй байна. Мөн дээжийн зураг авах зориулалт бүхий 450 налуу байрлалтай 3 ширээ, дээд талд нь эгц туссан гэрэлтэй ширээ байна. /Хавсралт №1-ийн зураг-1/

6.59.Гүйцэтгэгч нь хээрийн суурин боловсруулалт гүйцэтгэх 4-6 хүний багтаамжтай зөөврийн сууц / контейнер / 1 ширхэг байна. Зөөврийн байр нь дотроо 4-6 хүний бичгийн ширээ, сандалтай тохижуулсан байна. /Хавсралт №1 зураг-3/

6.60.Гүйцэтгэгч нь нүүрсний болон чулуулгийн дээж хадгалах зориулалт бүхий 8x10 метрийн хэмжээтэй хөргүүртэй зөөврийн байр 1 ширхэг /Хавсралт-1 зураг-4/

6.61.Дээрх хайгуулын ажлын хээрийн ажилд ашиглах барилга, зөөврийн байрны зохион байгуулалт, тохижилтыг Захиалагч талын саналаар өөрчилж болно.

6.62.Гүйцэтгэгч нь бараа материал хадгалах зориулалт бүхий дотроо тавиуртай 6x8 метрийн хэмжээтэй зөөврийн байр 1 ширхэг /Хавсралт №1 зураг-4/

6.63.Гүйцэтгэгч нь жолооч болон 2 суудлын авто машин, түлшээр хангана.

6.64.Гүйцэтгэгч нь өөрийн тээврийн хэрэгслээр Захиалагч талын инженер техникийн ажилчдын ээлжийг солино.

6.65.Гүйцэтгэгч тал нь өөрсдийн ажилтнуудыг орон байр, унаа, хоол хүнсээр хангах бөгөөд өрөмдлөгийн хэвийн, тасралтгүй ажиллах арга хэмжээ авч ажиллана.

6.66.Гүйцэтгэгч компани нь өөрийн хөрөнгөөр 4-5 худгийн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтанд бэлтгэж бүрэн тоноглож Захиалагч талд хүлээлгэн өгнө.

6.67.Гүйцэтгэгч тал нь захиалагч талын 4 геологичдыг гадаадад нүүрсний нарийвчилсан шинжилгээний сургалтад хамруулах эсхүл гадаадад 1-2 геологичийг магистрийн хөтөлбөрт хамруулна.

## ДОЛООДУГААР ЗҮЙЛ. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

7.1. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил тус бүрийг /KPI/-ыг дараах байдлаар үнэлж оноо өгнө. Үүнд:

7.1.1. Өрөмдлөгийн ажил
- Цооног тус бүрийн өрөмдлөгийн гүйцэтгэл (75 оноо).
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10 оноо).
- Байгаль орчин, нөхөн сэргээлт (10 оноо)
- Гэрээний үүргийн хэрэгжилт (5 оноо)

7.1.2. Цооногийн геофизикийн ажил
- Цооног тус бүрийн хэмжилт бүрэн гүйцэтгэсэн (80 оноо).
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (10 оноо).
- Байгаль орчин, нөхөн сэргээлт (5 оноо)
- Гэрээний үүргийн хэрэгжилт (5 оноо)

7.1.3. Нүүрсний дээж шинжилгээ
- Тухайн сарын дээж шинжилгээний гүйцэтгэл (50 оноо).

ХЭЗГ №01



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
ИЛ БОЛСОН

- Хөндлөнгийн шинжилгээний үр дүн нь лабораторийн стандарт зөрүүнд байгаа эсэх (40 оноо).
- Гэрээнд заасан гүйцэтгэгчийн үүргийн хэрэгжилт (10 оноо).

7.1.4. Чулуулаг болон хөрсний дээж шинжилгээ

- Тухайн сарын дээж шинжилгээний гүйцэтгэл (50 оноо).
- Хөндлөнгийн шинжилгээний үр дүн нь лабораторийн стандарт зөрүүнд байгаа эсэх (40 оноо).
- Гэрээнд заасан гүйцэтгэгчийн үүргийн хэрэгжилт (10 оноо).

7.2. Энэ гэрээний 7.1-д заасан оноог Хавсралт №-д заасан үзүүлэлтээр тооцож гэрээний гүйцэтгэлд сар бүр үнэлгээг Захиалагч өгнө.

7.3. Тухайн сарын Гүйцэтгэгчийн KPI оноо, үнэлгээг Захиалагчийн хяналт тавих эрх бүхий албан тушаалтан өгөх бөгөөд төслийн удирдлагын багийн гишүүд эцсийн байдлаар баталгаажуулна.

7.4. Захиалагч сар бүр үнэлэлт өгөхтэй холбоотойгоор Гүйцэтгэгч сар бүрийн тайлангаа гаргаж Захиалагчид танилцуулна.

7.5. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын сар бүрийн KPI оноог гаргаж 90 онооноос доош хасагдах оноог тухайн сард гүйцэтгэсэн ажлын мөнгөн дүнгийн 0.2 хувиар үржүүлэн Гүйцэтгэгчид төлөх нийт төлбөрөөс хасаж тооцно.

7.6. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын KPI оноо 3 сар дараалан 80 онооноос бага оноогоор дүгнэгдсэн тохиолдолд Захиалагчийн саналаар гэрээг 1 сарын дараа цуцлах үндэслэл болно.

## НАЙМДУГААР ЗҮЙЛ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР:

8.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /цаашид "ХАБЭА" гэх/-тай холбоотой аливаа зөрчил, үйлдвэрлэлийн осол, Осолд дөхсөн тохиолдол /цаашид "ОДТ" гэх/ болон эмнэлгийн яаралтай тусламж, галын тохиолдол, байгалийн гамшиг, тоног төхөөрөмжийн ослын үед талууд өөрсдийн хариуцсан талбай, объектыг үл харгалзан шаардлагатай тусламжийг цаг алдалгүй өгнө. Мөн түншлэлийн гишүүн компани бүр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны асуудлаар Захиалагчийн өмнө бүх хариуцлага хүлээж ажиллана.

8.2. Гүйцэтгэгч нь гэрээт ажил, түүний бэлтгэл ажлуудыг гүйцэтгэхдээ Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хариуцаж ажиллах бөгөөд холбогдох менежментийн төлөвлөгөө /ХАБЭА-ын бодлого, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөө/ жил бүр боловсруулан, Захиалагчаар батлуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.

8.3. Гүйцэтгэгч нь Захиалагчийн баталсан ХАБЭА-тай холбогдох дүрэм, журам, горим, зааврыг дагаж мөрдөнө.

8.4. Гүйцэтгэгч нь үүссэн аюул эрсдэлтэй ажлын байр болон нөхцлийг бүх ажлын байруудад арилгасаны дараа үйл ажиллагааг захиалагчийн зөвшөөрлөөр эхлүүлнэ. Гүйцэтгэгч нь Захиалагчийн зөвшөөрөлгүй буюу засч залруулах арга



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
ИЛ БОЛСОН

хэмжээг хангалтгүй авсан үед үйл ажиллагаагаа дур мэдэн эхлүүлсэн эхний тохиолдолд ХАБЭА, БОУБ-н гүйцэтгэлийг дүгнэх түлхүүр үзүүлэлтийн ХАБ-ын хэсэгт харгалзах хувийг бүхлээр нь; 2 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд тухайн сард төлөх ёстой байсан төлбөрийн ХАБЭА, БОУБ хэсэгт харгалзах хувийг бүхлээр нь шууд хасах; 3 дахь удаа уг зөрчлийг давтан гаргаж үйл ажиллагаагаа Захиалагчийн зөвшөөрөлгүй эхлүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

8.5. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу гүйцэтгэх ажлуудад зориулан аюулгүй ажиллагааны дүрэм, журам, горим, зааврыг Захиалагчийн холбогдох дүрэм, журам, горим, заавартай нийцүүлэн боловсруулж, батлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах бөгөөд шаардлагатай эрсдэлийн үнэлгээг хийсэн байна.

8.6. Гүйцэтгэгч нь Захиалагчийн инженер техникийн ажилтан, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй байгаль орчны ажилтныг ажлын талбайд зохих журам, горим, зааврын дагуу саадгүй нэвтрүүлэх бөгөөд тэдгээр ажилтны Захиалагчийн холбогдох дүрэм, журам, горим, зааварт нийцүүлэн тавьсан үндэслэл бүхий шаардлагыг бүрэн биелүүлэх үүрэгтэй.

8.7. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ХАБЭА-н талаарх үүргээ Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй.

8.8. Гүйцэтгэгч нь хайгуулын ажлыг гүйцэтгэх бүсэд ажиллуулах бүх ажилтан болон тоног төхөөрөмжийг Захиалагчид урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл хүсэх үүрэгтэй.

8.9. Гүйцэтгэгчийн бүх техник, гэрээт болон үндсэн ажилтан нь уурхайн бүсэд нэвтрэхдээ Захиалагчийн зохих дүрэм, журам, горим, зааврын дагуу зааварчилгаанд хамрагдсан байна.

8.10. Гүйцэтгэгч нь ХАБЭА-н тухай хуулийн дагуу хайгуулын талбайд ажиллаж байгаа өөрийн ажилтны /гүйцэтгэлийн бүх ажилтнууд, туслан гүйцэтгэгчдийн ажилтнууд/ ХАБЭА-н талаар хүлээх үүрэг хариуцлагыг бүрэн хариуцаж ажиллах ба энэ гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх явцад гарсан аливаа ослыг өөрийн нэр дээр бүртгэж, ажилтанд хууль тогтоомжид заасан нөхөн төлбөрийг төлнө.

8.11. Гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан бүсийн замын тэмдэг, тэмдэглэгээг бүрэн хариуцаж байрлуулах, шилжүүлэх ажлыг журмын дагуу гүйцэтгэн засвар үйлчилгээг тогтмол хийж байна.

8.12. Гүйцэтгэгч нь эрсдэлтэй ажил болон нийт ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийж түүнийхээ дагуу зохих арга хэмжээг авч ажиллана.

8.13. Ажилтнуудаас согтууруулах ундааны сорил авч түүнийгээ Захиалагчид мэдээлж ажиллана.

8.14. Ажлын байрны үзлэгийг Захиалагчийн дүрэм, журам, горим, зааврын дагуу хийж үзлэгээр илэрсэн зөрчлийг цаг тухайд нь арилгаж, тайланг Захиалагчид тухай бүр хүргүүлнэ.

8.15. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн явцад гарсан технологийн болон аливаа ажил үйлчилгээний доголдлын талаар Захиалагчаас мэдэгдсэний дагуу заасан хугацаанд арга хэмжээ авч, Захиалагчид танилцуулсны дараа хэвийн үйл ажиллагаар эхэлнэ.

8.16. Гүйцэтгэгч нь аюул, эрсдэлтэй нөхцөлийг бүх ажлын байранд арилгасны дараа үйл ажиллагааг Захиалагчийн зөвшөөрлөөр эхлүүлнэ.

ХЭЗГ
№01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛГЭЭСЭН

## ТАЙЛАН МЭДЭЭНИЙ ТАЛААР:

8.17. Гүйцэтгэгч нь аливаа осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдол, гэмтэл, өмчийн эвдрэл, зөрчлийн мэдээ, мэдэгдэл, тайланг Захиалагчид дараах байдлаар заасан хугацаанд өгч байна.

8.17.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдол, өмчийн эвдрэл, зөрчил гарсан даруйд (боломжит шуурхай хугацаанд буюу 5 минутын дотор) гар утсаар тухайн ээлжийг хариуцсан Захиалагчийн заасан ажилтанд мэдэгдэнэ.

8.17.2. Тухайн тохиолдол болсноос хойш 3 цагийн дотор "Урьдчилсан мэдэгдлийн хуудас"-аар Захиалагчид[2] хүргүүлнэ.

8.17.3. Мөн 72 цагийн дотор Захиалагчийн судалгааны маягтаар Судалгаа хийж тайлангаа Захиалагчид хүргүүлнэ.

8.17.4. Гүйцэтгэгч нь ХАБЭА-н талаар хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайланг 7 хоног, сар, хагас жил, жилээр Захиалагчид гаргаж өгнө.

8.17.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны сар, улирал, жилийн тайланг тогтсон маягтын дагуу дараа сарын 2-ны дотор багтаан Захиалагчид гаргаж өгнө.

8.17.6. Гүйцэтгэгч нь Захиалагчийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн ажил болон осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдол, өмчийн эвдрэл, гэмтэл, зөрчлийн мөрөөр авсан арга хэмжээний тайлангаа тогтсон хугацаанд багтаан Захиалагчид хүргэж өгсөн байна. Захиалагч уг мэдээ тайланг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд нэмэлт материал[3] шаардаж болно.

8.17.7. Гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааны нууцад хамаарагдах, патентын эрх, технологийн горимтой холбоотой болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад Захиалагчийн хүссэн энэ гэрээний дагуу хийж гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг заасан хугацаанд нь шуурхай гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

8.17.8. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаандаа Монгол улсын хууль, тогтоомжийн дагуу төрийн байгууллагуудад гаргаж өгөх шаардлагатай тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж өгөх үүрэгтэй.

8.17.9. Гүйцэтгэгч нь сургалт, зааварчилгаанд хамруулах ажилтнуудынхаа холбогдох мэдээллийг гарган Захиалагчийн сургалт хийх хуваарьт өдрөөс 48 цагийн өмнө Захиалагчийн ХАБЭА-н хэлтэст хүргүүлнэ.

## ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, БАРАА, МАТЕРИАЛЫН ХАНГАЛТЫН ТАЛААР:

8.18. Гүйцэтгэгч нь өөрийн ажил үүргийн хүрээнд ХАБЭА-н чиг үүрэгтэй холбоотой хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах бөгөөд осол, гэмтэл, эд хөрөнгийн эвдрэл, байгаль орчныг доройтуулсан зэрэг аливаа зөрчлөөс үүсэх бүх зардал, холбогдох хариуцлагыг бүрэн хариуцна. Гүйцэтгэгч нь өөрийн хариуцсан хэсгийн үйл ажиллагаанд ХАБЭА-н тухай хууль болон бусад хууль, тэдгээртэй холбогдох дүрэм, журам, заавар, горимыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай дараах техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, бараа материалын хангалттай нөөцийг бүрдүүлсэн байна.

8.18.1. Онцгой байдлын үед 24 цагаар бэлэн байдалд ажиллах, зохих сургалтад хамрагдсан, томилогдсон багтай байх;

8.18.2. Осол аваарын үед 24 цагаар ажиллах аврах, гал унтраах багтай байх;

ТАВАНТОЛГОЙ ХК ХЭЗЛ №01

---

[2] Захиалагчийн ХАБЭА-н хэлтэст

[3] Гүйцэтгэгчээс шаардсан нэмэлт материалыг бүрдүүлэх хугацааг заавал нэмж олгохгүй байж болно.



ЭТТ-ШИПЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

8.18.3. Тоосжилт ихэссэн тохиолдолд ус болон бусад эх үүсвэрээс шалтгаалсан тоосжилт намдаах, ундарга сайтай өөрийн гаргасан худагтай байх;

8.18.4. Согтууруулах ундаа, мансууруулах бодисын байнгын хяналтыг хийх зориулалт бүхий сорилын аппараттай байх, энэ аппарат нь бүх ээлж, ажлыг байранд тогтмол хяналт хийх хүрэлцээ, хангалттай байх;

8.18.5. Ажилтнуудын өдөр тутмын ажлыг хэвийн гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай, Захиалагчийн журмаар[4] заасан Нэг бүрийн болон Тусгай хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан байх;

8.18.6. Ажилтнуудыг амралтын хотхон болон ажлын байр хооронд зөөвөрлөх зориулалт бүхий стандарт шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэй байх;

8.18.7. Ажилтнуудын эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан тохь тухтай амрах байртай байх;

8.18.8. Эрүүл ахуйн шаардлага хангасан халуун хоол, ус, хүнсний иж бүрэн үйлчилгээтэй байх;

8.18.9. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбоотой гарч байгаа бүх төрлийн хог хаягдлыг хууль стандартын дагуу боловсруулах, устгах техник, хүн хүчээр хангагдсан[5] байх;

8.18.10. Үндсэн тоног төхөөрөмжөөс гадна тоосжилтыг дарах, зам талбайг арчлах, гэрэлтүүлгээр хангах ажлуудыг цаг улирлын ямар ч нөхцөлд саадгүй зохион байгуулах чадамж бүхий техник хэрэгслийн нөөцтэй байх;

8.18.11. Байгаль орчинд учрах хор хохирлыг цаг алдалгүй устган саармагжуулах, арилгахад шаардлагатай багаж хэрэгслийн хангалттай нөөцтэй байх;

8.18.12. Аливаа гамшиг, ослын үед дайчлан ажиллах хүн хүч, техник хэрэгсэл, санхүүгийн хангалттай нөөцтэй байх;

8.18.13. ХАБЭА-н чиглэлээр ажилтнуудаас өгсөн аливаа мэдээлэл, Аюулыг мэдээлэх хуудас, санал гомдлыг шуурхай шийдвэрлэж эргэн мэдэгдэх үүрэг хүлээнэ. Аюулыг мэдээлэх хуудасны шийдвэрлэлтийн талаар Захиалагчид өгөх мэдээндээ тайлагнасан байна.

8.18.14. ХАБЭА-тай холбоотой аливаа зөрчил дутагдал гарсан тохиолдолд Захиалагч нь зөрчлийг арилгуулах, цаашилбал хүний амь нас, эрүүл мэндэд хохирол үзүүлж болохуйц аюул, эрсдэлтэй нөхцөл Гүйцэтгэгчийн аль нэг ажлын байр болон үйл ажиллагаанд үүссэн тохиолдолд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ХАБЭА-хариуцсан албан тушаалтан болон Захиалагч нэгжийн Гүйцэтгэгчийн тухайн ажлын байрыг сул зогсолтын төлбөр төлөхгүйгээр зогсооно.

## ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

9.1. Талууд Захиалагчийн уурхай буюу салбар дээр ажил эхлүүлэх акт үйлдсэнээр гэрээний гүйцэтгэл эхэлнэ.

9.2. Гэрээний хугацаа нь Талууд гэрээний 9.1-т заасан Үйлчилгээ үзүүлж эхлэх акт үйлдсэн өдрөөс хойш 24 сарын хугацаатай байна.

9.3. Хайгуулын ажлын боловсруулалт, төлөвлөлтийн оновчлолтой холбоотойгоор

---

[4] Захиалагчийн НБХХ-тэй холбоотой дүрэм, журам, горим, зааврын холбогдох заалтыг хөнгөрүүлсэн байж болно. Өөрөөр хэлвэл энд заагдаагүй хувцас хэрэглэлийг нэмэлтээр олгож болно.

[5] Эдгээр асуудлыг гэрээгээр зохицуулсан байж болно.



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

өрөмдлөгийн ажлыг Захиалагч талаас 2-4 удаагийн давтамжтайгаар 7-14 хоногийн хугацаанд түр зогсолт хийж болно. Тухайн түр зогсолтод хамаарах хугацааг гэрээний хугацаанд оруулан тооцогдохгүй.

ИЛ БОЛСОН

9.4. Гэрээний хугацааг хуанлийн хугацаагаар тодорхойлно.

9.5. Гэрээний хугацаа дуусахад талууд хайгуулын хээрийн талбайд акт үйлдэх бөгөөд холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулна.

## АРАВДУГААР ЗҮЙЛ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

10.1. Гүйцэтгэгч энэ гэрээний хавсралт ажлын даалгаврын дагуу ажлыг зохих хугацаанд биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувийн алдангийг Захиалагчид төлнө. Нийт гэрээнд оногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10 хувиас ихгүй байна.

10.2. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувь хүртэл байна.

10.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас Гэрээ цуцлагдах болсон тохиолдолд Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

10.4. Талуудын аль нэг нь өөрийн гэм буруутай үйлдлийн улмаас нөгөө талдаа хохирол учруулсан бол хохирлыг бүрэн хариуцаж арилгах үүрэг хүлээнэ.

10.5. Гүйцэтгэгч нь Гэрээнд заасан үүргээ зөрчсөн, ажил гүйцэтгэх чадамжгүй болсоноос үүдэн гарах аливаа хууль зүйн үр дагавар болон эдийн засгийн хохирлыг дангаар хариуцна.

10.6. Ажлын гүйцэтгэлд ямар нэгэн доголдол гарсан нь боловсруулалтын шатанд тодорхой болсон тохиолдолд ажлыг хүлээн авсанаас хойш 1 /нэг/ жилийн хугацаанд Захиалагч гомдол гаргаж болно.

10.7. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас гэрээ цуцлагдах болсон тохиолдолд Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг Гүйцэтгэгч бүрэн нөхөн барагдуулах үүрэг хүлээнэ.

10.8. Гэрээнд дурьдаагүй нөхцөл байдал, асуудлыг шийдвэрлэхэд Монгол улсын хууль тогтоомжийг удирдлага болгоно.

## АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

11.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа ажлын 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдож болно.

11.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн долоо хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж болно.

11.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

ХЭЗГ
№01



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

## АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

ИЛ БОЛСОН

12.1. Талууд харилцан тохиролцсоноор Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж талуудын гарын үсгээр баталгаажуулж, гэрээнд хавсаргана. Ийнхүү оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөрт тооцогдох бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

12.2. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс шийдвэрлэж чадвал Монгол Улсын хуулийн дагуу, Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛГОХ

13.1. Дараах тохиолдлуудад аль нэг тал хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө гэрээг цуцлах тухай мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлсний үндсэн дээр гэрээг цуцалж болно. Үүнд:

13.1.1. аль нэг тал энэ гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн ба нөгөө талаас алдааг илрүүлж түүнд мэдэгдсэнээс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд багтаан залруулаагүй бол,

13.1.2. аль нэг тал төлбөрийн чадваргүй болсон эсвэл дампуурсан бол,

13.1.3. аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс болж нөгөө талд төлөгдөх алдангийн дээд хувь хэмжээнд хүрсэн тохиолдолд,

13.2. Гэрээний 8.4 эсхүл 7.6-д заасан нөхцөл байдал үүссэн бол Захиалагч гэрээг цуцлах мэдэгдлийг нэн даруй өгнө.

## АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД ЗААЛТ

14.1. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

14.2. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болсонд тооцно.

14.3. Гүйцэтгэгчээс ирүүлсэн Түншлэлийн гэрээ нь энэ гэрээнд нийцсэн байна. Гүйцэтгэгчээс Түншлэлийн гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээнд нийцсэн байх бөгөөд энэ гэрээний аль нэг заалттай зөрчилдөх тохиолдолд энэ гэрээний заалтыг баримтлана.

14.4. Энэхүү гэрээний үүргийг давагдашгүй хүчин зүйл (нийтийг хамарсан ажил хаялт, эдийн засгийн хямрал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гал түймэр, үер усны гамшиг болон бусад байгалийн гамшигт үзэгдэл, гадаад худалдааны хорио цээр болон экспорт, импортын хориг, терроризмын аливаа үйлдэл, цар тахал гэх мэт)-ийн улмаас биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тал нь энэ тухай нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

14.5. Энэ гэрээнд дурдаагүй асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг удирдлага болгоно.

14.6. Энэ гэрээний нууцлалд талуудын санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад холбогдох мэдээ, мэдээлэл, түүнчлэн талуудын зөвхөн өөр хоорондоо харилцан мэдээлсэн тоо баримт, эрх зүйн бичиг баримтууд хамаарах бөгөөд талууд гэрээний нууцлалд хамаарах мэдээ, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусад гуравдагч этгээдэд шилжүүлэх, задруулахыг хориглоно.

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

ИЛ БОЛСОН

14.7. Гэрээг монгол хэл дээр 6 хувь үйлдэх бөгөөд Захиалагч 2 хувь, Гүйцэтгэгч 4 хувь тус бүр авах бөгөөд гэрээний хувиуд адил хүчинтэй байна.
14.8. Гэрээнд холбогдох аливаа асуудлаар талууд албан бичгээр харилцана.
14.9. Гэрээнд дор дурьдсан баримт бичгийг хавсаргасан ба эдгээр баримт бичгүүд нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.
14.9.1. Хавсралт №1 Ажлын даалгавар
14.9.2. Хавсралт №2 Гүйцэтгэгчийг үнэлэх үзүүлэлт
14.9.3. Хавсралт №3 Нарийвчилсан шинжилгээ гүйцэтгэх дээжийн тоо
14.9.4. Хавсралт №4 Гүйцэтгэгчийн тендерт санал болгосон үнэ
14.9.5. Хавсралт №5 Түншлэлийн гэрээ
14.9.6. Хавсралт №6 Үнийн тохиргоо хийх аргачлал
14.9.7. Хавсралт №7 Бусад хавсралт

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК-ИЙН УУЛ УУРХАЙ, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА

Д.УУЖИМСАНАА

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ХАМТАРСАН ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮН, "ЭЛГЭН" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ ЗАХИРАЛ

У.ХҮРЭЛБААТАР

**ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:**

"Эрдэнэс Тавантолгой" ХК Финанс төв, Жигжиджав-8 Чингэлтэй дүүрэг, 1-р хороо Улаанбаатар хот-15160
Шуудангийн хаяг: info@erdenestt.mn
Утас:976-7505 5555

"Элгэн" ХХК Гранд оффисийн байр, 62 тоот Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
Шуудангийн хаяг: info@elgendrilling.mn
Утас:976-7011 3839

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗЭ
№01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ

ИЛ БОЛСОН

# “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ТАВАНТОЛГОЙ ОРДЫН ДАЛД УУРХАЙН ХАЙГУУЛ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ, АЖЛЫН ЗОРИЛГО

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн коксжих нүүрсний ордын талбайд геологи, хайгуулын ажлын цогц ажлыг гүйцэтгэх замаар тэргүүн ээлжид далд аргаар ашиглах хэсгийн судалгааны төвшинг ахиулах, геологийн болон структурыг тогтоцыг тогтоох, нүүрсний дээжид анхан шатны техникийн болон нарийвчилсан шинжилгээг гүйцэтгэж, нүүрсний чанарын үзүүлэлтийг тодорхойлох, чөмгөн дээжид чулуулгийн физик механик, геомеханикийн шинжилгээ гүйцэтгэж, далд уурхайн хажуугийн тогтворжилтыг судлах, олборлолтын бэлтгэл ажлыг хангах зорилгоор ажлыг төлөвлөсөн.

## ХОЁР. АЖЛЫН НЭР, ХЭМЖЭЭ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгой ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд нийт 123,000 тууш метр баганат өрөмдлөг болон цооногийн геофизикийн ажил, нүүрсний анхан шатны техникийн болон коксжих шинж чанарын 20,500 ширхэг (хавсралт-2), анхан шатны баяжуулалт, нүүрсний нүүрс баяжуулах туршилт болон холбогдох шинжилгээ, (хавсралт-3), гүн баяжуулалтын туршилт болон холбогдох шинжилгээ, (Хавсралт-4), болон нарийвчилсан (Хавсралт-5) шинжилгээний буюу нийт 4200 ширхэг дээжид, чулуулаг-6210, хөрс-1000, геотехникийн-1400 (Хавсралт-6) дээжид физик-механикийн шинж чанар тодорхойлох шинжилгээний ажлыг тус тус гүйцэтгэнэ.

Нүүрсний давхаргын тархалт, хурдас чулуулгийн зузаанаас хамаарч нүүрс болон чулуулгийн дээжийн тоо өөрчлөгдөж болно.

## ГУРАВ. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ, ХУГАЦАА

Ажлын цар хүрээ нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тэргүүн ээлжид далд аргаар ашиглах талбайн хүрээнд Геологийн албаны зүгээс боловсруулсан ажлын даалгавар болон холбогдох хайгуулын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

Захиалагч болон Гүйцэтгэгч нар нь гэрээнд гарын үсэг зурж, гэрээний дагуух ажил эхлүүлсэн баримтыг хоёр талаас үйлдсэн өдрөөс эхлэн өрөмдлөг, цооногийн

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК ХЭЗГ

геофизикийн ажлыг 18 /арван найм/ сар, нүүрсний болон чулуулгийн дээж шинжилгээ, туршилтын ажлыг 24 /хорин дөрөв/ сарын хугацаанд ажлыг гүйцэтгэнэ.

Хайгуулын ажлын боловсруулалт, цооногийн төлөвлөлтийн оновчлолтой холбоотойгоор өрөмдлөг, цооногийн гефизикийн ажлыг захиалагч талаас 3-4 удаагийн давтамжтайгаар 7-14 хоногийн хугацаанд түр зогсолт хийж болно. Тухайн түр зогсолт нь гэрээний хугацаанд тооцогдохгүй.

Жич: Тус хайгуулын ажлыг гүйцэтгэгч компанитай гэрээг зохих журмын дагуу байгуулсны дараа хоёр талаас ажил эхлэх акт үйлдэн баталгаажуулснаар хээрийн ажил эхэлнэ.

Ажил эхлүүлэх акт үйлдсэнээс хойш сар бүрийн эхний ажлын 5 хоногт багтаан гэрээний хэрэгжилтийн дүгнэлтийн хурлыг захиалагч талаас зохион байгуулж, тухайн сарын ажлын гүйцэтгэл, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг баталгаажуулна. Захиалагчийн талаас хурлыг товыг өөрчилж болно.

## ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### 4.1 ӨРӨМДЛӨГИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ

#### 4.1.1 Ерөнхий шаардлага

✓ Гүйцэтгэгч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна.

✓ Компани нь 10-с доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх ба 10-аас доошгүй ижил төстэй нүүрсний орд дээр холбогдох ажил, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байна.

✓ Компанийн толлох мэргэжилтэн болох өрмийн мастер нь мэргэжлийн үнэмлэх, сертификаттай байх бөгөөд тухайн чиглэлээр 5-с дээш жил ажилласан туршлагатай байна.

✓ Өрөмдлөгийн багийн удирдагч нь компанийн үндсэн ажилтан байх ба мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан байна.

#### 4.1.2 Ажлын даалгавар

✓ “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Тавантолгой ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд геологи, хайгуулын 123,000 тууш метр баганат өрөмдлөгийн ажил гүйцэтгэнэ.

✓ Гүйцэтгэгч нь өрөмдлөгийн ажлын арга аргачлал, гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, танилцуулгын хамт захиалагч талд ирүүлнэ.

✓ Хайгуулын бүх цооногийг диамонд /гулуузан дээжтэй/ өрөмдлөгийн аргачлалаар гүйцэтгэнэ.



НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХСЭГ
№01
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

- ✓ Хайгуулын өрөмдлөгийн диаметр–HQ 63.5 мм байна. Хайгуулын ажлыг удирдаж буй нэгжийн зөвшөөрлийн дагуу өрөмдлөгийн диаметрийг өөрчилж болно.
- ✓ Гүний цооног өрөмдөхтэй холбоотойгоор өрмийн машин тус бүр 200 тууш метр өрөмдөх PQ диаметрийн цооногийн штангтай, 1000 тууш метр өрөмдөх HQ диаметрийн цооногийн штангтай байна.
- ✓ Өрөмдлөгийг ялтастай өрөмдөх ба өрөмдлөгөөр керн гарч ирсэн даруйд цэвэр усаар угааж цэвэрлэн, ялтсан дээр керний хагарал бутрал, чиглэлийг сум бүхий зураасаар тэмдэглэнэ.
- ✓ Өрөмдлөгийн ажлын явцад нүүрс болон чулуулгийн гарц 95 хувиас их, нийт нүүрсний давхраасын кернийн 10-аас дээш хувь нь өрөмдлөгийн үйл ажиллагааны улмаас үйрч бохирдсон, зорилтот гүн хүртэл өрөмдлөгийн үйл ажиллагаа явагдаагүй, дараагийн шатны судалгааг бүрэн хийх боломжгүй болсон тохиолдолд тухайн цооногийн өрөмдлөгийн ажлыг шаардлага хангалтгүй гүйцэтгэсэнд тооцон Захиалагч хүлээн авахгүй /актлах/ бөгөөд баримт үйлдэн баталгаажуулна.
- ✓ Өрөмдлөгийн үйл ажиллагаанаас хамааран өрмийн дээж нь өрмийн шингэн болон бусад зүйлээр бохирдсон, хэт нунтаглагдсан, хайрцагласан дээжийн дугаарлалт, интервал алдаатай тэмдэглэгдсэн, тээвэрлэлтийн явцад эвдэрч гэмтсэн энэ нь шинжилгээнд сөргөөр нөлөөлөх тохиолдолд тухайн гэмтсэн хэсгийг керн алдалтаар тооцож улмаар цооногийн өрөмдлөгийн ажлыг шаардлага хангалтгүй гүйцэтгэсэнд тооцно.
- ✓ Өрөмдлөгийн шаардлага хангаагүй өрөмдсөн цооногт гүйцэтгэсэн геофизикийн хэмжилтийн зардлыг өрөмдлөг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцана.
- ✓ Цооногийн ханыг зориулалтын материалаар барьцалдуулан, өрөмдлөгийн ажлын аргачлалын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд цооногийн геофизикийн хэмжилт, усны хэмжилт гэх мэт мөн шаардлагатай тохиолдолд цооног тасалж open hole геофизикийн хэмжилт хийх нөхцөлийг хангаж ажиллана.
- ✓ Хайгуулын ажлыг удирдаж буй геологичийн сонгосон эсвэл нүүрсний давхраас метан хий илэрсэн цооног бүрд нүүрсний давхраасын метан хийн агууламжийг тодорхойлох хэмжилтийн ажлыг гүйцэтгэх нөхцлийг хангаж ажиллана.
- ✓ Өрөмдлөгийн ажил гүйцэтгэснээс хойш цооног бүрд гүний усны төвшинг тодорхой хугацааны дараа хэмжих бөгөөд Гүйцэтгэгч тал нь гүний усны статик төвшинг хэмжих нөхцөлийг бүрдүүлж ажиллана. (24, 48 болон 72 цагийн дараа гэх мэт).

ХЭЗГ
№01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

- Өрөмдлөгийн ажлын явцад өрмийн хуудас бичиглэлийг аргачлалын дагуу хөтөлж, цооног хаасны дараа баталгаажуулан холбогдох бичиг баримтын хамт хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч нь шаардлагатай тохиолдолд өрөм дээр 3 метр урттай ялтастай дээжийн анхан шатны бичиглэл хийх ширээ тавиуртай, зураг дарах гэрэлтүүлэгтэй, эйр кондишен, халаалттай зөөврийн байраар хангана.
- Гүйцэтгэгч тал нь өрөмдлөгөөс гарсан кернийг цэвэрлэн зориулалтын хайрцаганд савлан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хээрийн геологийн оффист өөрийн унаагаар тээвэрлэлтийн эвдрэл, гэмтэлгүй, тогтсон хугацаанд хүргэж өгнө.
- Хайгуулын ажлын гүйцэтгэл, уул геологийн нөхцөл, хайгуулын ажлын төлөвлөгөөнөөс хамаарч өрмийн машины тоог Захиалагч тал урьдчилан Гүйцэтгэгч талд мэдэгдсэний дагуу тоог өөрчилж болно.
- Өрөмдсөн цооногийн хаягжуулалт, өрөмдлөгийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн байгаль орчныг нөхөн сэргээх дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэж, цооног тус бүрийг зургаар баталгаажуулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Цогтцэций сумын ЗДТГ-ын ажлын хэсэгт хүлээлгэн өгч Захиалагч талд дүгнэлт, актыг хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч тал нь өрөмдлөгийн ажил эхлэхээс өмнө Өмнөговь аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газартай ус ашиглах гэрээ болон Цогтцэций сумын тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулах ба ажил дууссаны дараа гэрээг дүгнэж баримтаа ирүүлнэ.
- Өрөмдсөн цооногийн гүнийг цооногийн геофизикийн хэмжилт бүрэн (open hole) хэмжилтийн гүнээр тооцон, тухайн цооногийн өрөмдлөгийн ажлын гүйцэтгэлийг хүлээн авна.
- Хайгуулын хээрийн ажил дуусч гэрээ дүгнэсэн акт үйлдэхээс өмнө өрөмдлөгийн ажлын нэгдсэн тайланг захиалагч талд хүлээлгэн өгнө.
- Гүйцэтгэгч компани нь өөрийн хөрөнгөөр 2-3 худгийн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтанд бэлтгэж бүрэн тоноглож Захиалагч талд хүлээлгэн өгнө.

**4.1.3 Техник, тоног төхөөрөмжийн шаардлага**

- Гүйцэтгэгч тал нь 8-10 /наймаас-арав/ өрмийн машин тогтмол ажиллах бөгөөд нэг өрмийн машин нь 1500 метр хүртэлх өрөмдөх хүчин чадал бүхий хоногт 40

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

тууш метрийн өрөмдлөг гүйцэтгэх өрмийн машин, өрмийн баг, машин тоног төхөөрөмжтэй байна.

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

- ✓ Техник, тоног төхөөрөмж, бусад багаж хэрэгслийн бүрэн байдлыг Захиалагч тал ажил эхлэх болон гэрээний хугацаанд хянаж ажиллана.
- ✓ Гүйцэтгэгч тал нь хайгуулын хээрийн ажил гүйцэтгэх хугацаанд Хавсралт-1 заасан зөөврийн байр болон хээрийн ажил гүйцэтгэх нөхцөлөөр хангаж ажиллах ба тухайн байрыг хайгуулын ажил дууссаны дараа “Эрдэнэс Тавантолгой” ХК-нд үнэ төлбөргүй шилжүүлнэ.
  - Геологийн бичиглэл, дээжлэлт гүйцэтгэх зориулалт бүхий дулаалга, халаагуур, эйр кондишен, шалтай (тоос босохооргүй), битүүмж сайтай, аюулгүй байдлыг хангасан, шаардлага хангасан гэрэлтүүлэг болон зориулалтын урт кернийн тавиур ширээгээр тоноглосон 1 ширхэг зөөврийн байр (25 метрийн урттай, 10 метрийн өргөнтэй, 2 талдаа хаалгатай, байгалийн гэрэл нэвтрэх цонхнуудтай байна) хангана. Зөөврийн байранд байрлуулах дээжийн бичиглэл гүйцэтгэх ширээний бүтэц нь зэрэгцээ 3 шугамтай, нэг шугамын урт 17 м-ээс багагүй урттай, хайрцагтай дээж саадгүй явуулах рольктой, Бичиглэл гүйцэтгэх ширээний дээр гүйдэг замтай лед гэрэлтэй байна. Мөн дээжийн зураг авах зориулалт бүхий $45^0$ налуу байрлалтай 3 ширээ, дээд талд нь эгц туссан гэрэлтэй ширээ байна. /хавсралт-1 зураг-1/
  - Хээрийн суурин боловсруулалт гүйцэтгэх 4-6 хүний багтаамжтай зөөврийн сууц / контейнер / 1 ширхэг байна. Зөөврийн байр нь дотроо 4-6 хүний бичгийн ширээ, сандалтай тохижуулсан байна. /хавсралт-1 зураг-2/
  - Нүүрсний болон чулуулгийн дээж хадгалах зориулалт бүхий 6х8 метрийн хэмжээтэй хөргүүртэй зөөврийн байр 1 ширхэг /хавсралт-1 зураг-3/
  - Бараа материал хадгалах зориулалт бүхий дотроо тавиуртай 6х8 метрийн хэмжээтэй зөөврийн байр 1 ширхэг /хавсралт-1 зураг-4/
  - Дээрх зөөврийн байрнуудын хэмжээг захиалагч талтай харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд засвар үйлчилгээг тогтмол хийж, геологичдыг тухайн байранд ажиллах нөхцөлөөр хангана.
  - Гүйцэтгэгч тал нь жолооч бүхий 1 бага оврын суудлын автобус, 2 суудлын авто машин, түлшээр хангана.
- ✓ Өрөмдлөгийн явцад шаардлагатай усны хэрэгцээг өөрсдийн зардлаар хангана. /худаг болон бусад эх үүсвэрээс/

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ
№01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

- ✓ Гүйцэтгэгч тал нь өөрсдийн ажилтнуудыг орон байр, унаа, хоол хүнсээр хангах бөгөөд өрөмдлөгийн хэвийн, тасралтгүй ажиллах арга хэмжээ авч ажиллана.

## 4.2 ЦООНОГИЙН ГЕОФИЗИКИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ.

### 4.2.1 Ерөнхий шаардлага

- ✓ Гүйцэтгэгч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх
- ✓ Гүйцэтгэгч тал нь 7-с доошгүй жил цооногийн геофизикийн хэмжилтийн үйл ажиллагаа явуулсан байх ба 10-аас доошгүй жил ижил төстэй нүүрсний орд дээр холбогдох ажил, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.
- ✓ Гүйцэтгэгч талын голлох мэргэжилтэн болох геофизикч нар нь мэргэжлийн диплом, үнэмлэх, сертификаттай тухайн чиглэлээр тавaас дээш жил ажилласан туршлагатай байх ба тухайн компанийн нийгмийн даатгалын дэвтрийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байна.
- ✓ Өдөр, шөнийн ээлжээр нэг ээлжиндээ 6-аас доошгүй геофизикчтэй байх.
- ✓ Цооногийн хэмжилт, судалгааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж буй ерөнхий геофизикч нь компанийн үндсэн ажилтан байх ба мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан байна.
- ✓ Орчин үеийн өндөр нарийвчлал бүхий acoustic televiewer эсвэл чулуулгийн давхраасын уналын чиглэл өнцгийг хэмжигч dipmeter багажны боловсруулалтыг хийх геофизикч нь зохих сургалтанд хамрагдсан гэрчилгээ /сертификат/ бүхий мэргэжсэн геофизикч байна.
- ✓ Цөмийн энергийн хуулийн дагуу цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэнэ.
- ✓ Цөмийн энергийн хуулийн дагуу цацрагтай ажиллагч ажилтнууд нь нэг ээлжиндээ хамгийн ихдээ 14 хоног уурхайн бүсэд ажиллахаар тооцож 2 ээлжийн (өдөр, шөнө, амарч буй ээлж зэрэг) 6 доошгүй мэргэжлийн геофизикчтэй байна
- ✓ Хээрийн анги өөрсдийн ажилтнуудыг орон байр, унаа, хоол хүнсээр хангана.
- ✓ Өндөр нарийвчлалтай өөрийн эзэмшлийн дижитал багаж төхөөрөмжтэй болон цацраг идэвхт үүсгүүрийн зохих зөвшөөрөл гэрчилгээтэй байх.

### 4.2.2 Ажлын даалгавар

- ✓ Тавантолгой ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд геологи, хайгуулын ажил гүйцэтгэх талбайн хүрээнд 123,000 тууш метр цооногийн хэмжилтийн ажил гүйцэтгэнэ.

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ
№01
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

- ✓ Гүйцэтгэгч нь цооногийн геофизикийн ажлын арга аргачлал, гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, танилцуулгын хамт захиалагч талд ирүүлнэ.
- ✓ Өрөмдсөн цооног бүрт геофизикийн доорх хэмжилтийг олон улсад хийгддэг аргачлалын дагуу бүрэн гүйцэтгэнэ.

1. **Dual density (short-spaced and long-spaced),**
2. **Natural gamma,**
3. **Acoustic Televiewer /Optic/ эвсэл Dipmeter,**
4. **Dual resistivity PR,**
5. **Down hole survey (deviation and azimuth),**
6. **Caliper**
7. **Sonic**

Жич: Dipmeter аргачлал нь Цооногийн босоо зүсэлтийн дагуух чулуулгийн унал , азимутын өнцгийг тодорхойлно.

**Багажны бүдүүвч схем**




**Жишээ:** $23^0$ –аар $45^0$ –ын азимутын өнцгөөр унасан унал

- ✓ Геофизикийн хэмжилтээр уст үеийг тодорхойлж, зохих судалгааг гүйцэтгэн зүсэлт зураг тайланд тусгана.
- ✓ Өрөмдлөгийн ажил гүйцэтгэснээс хойш цооног бүрд гүний усны төвшинг тодорхой хугацааны дараа хайгуулын ажлыг удирдаж буй нэгжийн төлөвлөгөөний дагуу холбогдох хэмжилтийг гүйцэтгэнэ.
- ✓ Dual Resistivity PR /Формацын цахилгаан эсэргүүцэл/ хэмжилтийн үзүүлэлтээр боломжтой уст үеүдийг ялгана.
- ✓ Тулгуур /эталон/ цооногт хоёр долоо хоног тутам багаж төхөөрөмжийн үнэн зөв ажиллагааг хянаж, захиалагч талд үр дүнг тогтмол ирүүлж танилцуулна.
- ✓ Цооногийн геофизикийн судалгааны анхдагч материалыг хэмжилт дуусмагц газар дээр нь тохирох масштабаар хэвлэж өгнө.



НУУЦ
ИЛ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

- ✓ Гүйцэтгэгч нь хээрийн ажлын үед хэмжилт гүйцэтгэсэн цооногийн мэдээллийг хэмжилт хийснээс хойш 12 цагийн дотор нүүрсний үе /өгөршсөн, исэлдсэн, коксжих үе/, давхраас, цооногийн хазайлт /deviation/ зэргийг тодорхойлж цооногийн геофизикийн анхан шатны логийг 1:200, нүүрсний үеийг 1:50 масштабаар тус тус хоёр хувь хэвлэн тоон форматын хамт тухайн хариуцсан геологичид хүлээлгэн өгнө.
- ✓ Гүйцэтгэгч нь хэмжилтийн ажилд үндэслэн нүүрсний давхарга болон чулуулгийн шинж чанар, литологийг тодорхойлох судалгаа хийнэ.
- ✓ Цооногийн геофизикийн хэмжилтийн геологийн зүсэлт /interpretation/ зургийг Dual density (short-spaced and long-spaced), Natural gamma, dipmeter, resistivity PR, caliper, sonic зэрэг хэмжилтийн үр дүн, өрөмдлөгийн кернийн бичиглэлийн, геофизикийн хэмжилтийн, харьцуулсан багануудаар үүсгэн, өнгөтөөр 2 хувь 1:200 масштабаар хэвлэсэн болон цахим форматын хамт хүлээлгэн өгнө.
- ✓ Цооногийн геофизикийн хэмжилтийн геотехникийн зүсэлт зургийг Acoustic Televiewer, Caliper, Deviation (three arm) зэрэг судалгааны үр дүн болон чулуулгийн геотехникийн туршилтын бичиглэл үр дүнг нэгтгэн боловсруулж, өнгөтөөр 2 хувь 1:200 масштабаар хэвлэн, цахим форматын хамт хүлээлгэн өгнө.
- ✓ Захиалагч талын загварын дагуу ажлын нэгдсэн тайланг боловсруулж хэмжилтийн ажил дууссаны дараа дээрх зүсэлтүүдийн хамт хүлээлгэн өгнө.
- ✓ Цооногийн хэмжилтийн гүнийг цооногийн геофизикийн хэмжилтийн бүрэн хэмжилтийн гүнээр буюу open hole гүнээр тооцож хүлээн авна.
- ✓ Цооногийн хэмжилтийн ажлыг гүйцэтгэх явцад санаатай болон санамсаргүй байдлаар мэдээллийг зассан, захиалагч талын геологийн зөвшөөрөлгүйгээр өрөмдлөгийн цооногийн уланд хүргэхгүйгээр хэмжилт хийсэн тохиолдолд тухайн цооногийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд 1-с дээш цооногт давтагдсан тохиолдолд гэрээг цуцлана.
- ✓ Хайгуулын хээрийн ажил дууся гэрээ дүгнэсэн акт үйлдэхээс өмнө өрөмдлөгийн ажлын нэгдсэн тайланг захиалагч талд хүлээлгэн өгнө.

**4.2.3 Техник, тоног төхөөрөмжийн шаардлага**

- ✓ Ажлын даалгаврын дагуу ажил гүйцэтгэх өөрийн эзэмшлийн 3-оос доошгүй бүрэн тоноглогдсон машинтай /станц байх/ бөгөөд тухайн машин нь dual density, gamma, acoustic televiewer эсвэл чулуулгийн давхраасын уналын чиглэл өнцгийг хэмжигч dipmeter, resistivity PR, caliper, deviation, sonic, усны төвшин хэмжигч

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ
ХЭЗГ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

зэрэг судалгаанд шаардагдах тоног төхөөрөмж, шаардлагатай сэлбэг, нөөц багажаар бүрэн хангагдсан байх шаардлагатай.

- ✓ Хайгуул судалгааны талбайд бүрэн тоноглогдсон 3-оос доошгүй машины / станцын багаж, тоног төхөөрөмжүүдийг тендерт оролцохоор ирүүлсэн материалын дагуу бүртгэж, багаж тоног төхөөрөмж нь бүрэн тохиолдолд/ үзлэгт оруулж ажил эхлүүлсэн акт үйлдэж, гэрээт ажлыг эхлүүлнэ.
- ✓ Цацраг идэвхит үүсгүүр бүхий тоноглосон машин / станц нь "Цөмийн энергийн хууль"-ийн дагуу цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах/, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэгч тал нь аюулгүй байдлыг бүрэн хариуцаж ажиллана.
- ✓ Геофизикийн техник, тоног төхөөрөмж, машин нь ямар нэг эвдрэл гэмтэлгүй байх бөгөөд хэмжилтийн тасралтгүй үйл ажиллагааг хангана.
- ✓ Цооногийн геофизикийн хэмжилтийн ажилд шаардлагатай цацраг идэвхт үүсгүүр бүхий багажууд нь мэргэжлийн хяналтын ерөнхий газар, цөмийн болон цацрагийн хяналтын газрын зөвшөөрөлтэй байх бөгөөд Гүйцэтгэгч талын геофизикч нар нь холбогдох аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна. Багадаа 100мкю-аас дээш хүчин чадалтай хоёроос доошгүй цацраг идэвхт үүсгүүртэй байна.

## 4.3 НҮҮРСНИЙ ТЕХНИКИЙН БОЛОН НАРИЙВЧИЛСАН ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭХ

### 4.3.1 Ерөнхий шаардлага

- ✓ Гүйцэтгэгч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна.
- ✓ Гүйцэтгэгч нь Монгол улсын стандартчилал, хэмжилзүйн газрын "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC 17025 стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, итгэмжлэгдсэн байна.
- ✓ Гүйцэтгэгч нь Олон улсын стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.
- ✓ Компани нь 7 доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх ба 5-аас доошгүй жил ижил төстэй коксжих нүүрсний орд дээр холбогдох ажил үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.
- ✓ Компанийн голлох мэргэжилтэн болох химичид нь мэргэжлийн үнэмлэх, сертификаттай байх бөгөөд тухайн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх.

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХЭЗГ №01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

- ✓ Компани нь нүүрсний дээж шинжилгээний чиглэлээр мэргэшсэн Гадаад зөвлөхтэй байна.
- ✓ Шинжилгээний багийн удирдагч нь компанийн үндсэн ажилтан байх ба мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан байна.
- ✓ Туршилт шинжилгээ хийх лаборатори ISO, MNS, GB стандартын дагуу дээрх шинжилгээг хийх туршлагатай мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна.
- ✓ Гүйцэтгэгч тал нь нүүрсний дээж шинжилгээний ажлыг Тавантолгойн орд дээр гүйцэтгэх, эсвэл хотод гүйцэтгэх талаар захиалагч талтай харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- ✓ Дээж шинжилгээний ажлыг хотод гүйцэтгэх тохиолдолд гүйцэтгэгч тал нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Өмнөговь аймгийн Цанхийн уурхайгаас өөрийн тээврийн хэрэгслээр нүүрсний дээжийг цаг тухай бүр (Хайгуулын ажлын удирдаж буй геологичийн өгсөн чиглэлийн дагуу) тээвэрлэнэ.
- ✓ Гүйцэтгэгч талд дээж хүлээлгэн өгсөнөөс дээж хадгалалт, тээвэрлэлтийн үед дээж гэмтсэн, алдагдсан, баглаа боодлын битүүмжлэл алдагдсан тохиолдолд хайгуулын дахин өрөмдөх, геофизикийн хэмжилтийн зардал зэрэг холбогдох зардлыг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.
- ✓ Дээжний үр дүнг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэгч компани нь тухайн сард шинжилсэн нийт дээжний 4 /дөрөв/ хүртэлх хувийг хөндлөнгийн шинжилгээ гүйцэтгэх бөгөөд өөрийн зардлаар шинжилгээ хийлгэж холбогдох чанарын абсолют зөрүү болон мэдээллийг захиалагч талд файлаар болон цаасаар хүргүүлэх үүргийг хүлээнэ. Хөндлөнгийн лабораторийг Захиалагч тал нь сонгох бөгөөд гүйцэтгэгч тал дээжийг хүлээлгэн өгнө.
- ✓ Хөндлөнгийн дээж шинжилгээний 20-оос дээш хувь нь лаборатори хоорондын зөвшөөрөгдөх стандарт зөрүүнээс их гарсан тохиолдолд түүнийг төлөөлж буй анхдагч дээжийн төлбөрийг Захиалагчаас нэхэмжлэх эрхгүй бөгөөд гэрээг цуцлах үндэслэл болно.
- ✓ Гүйцэтгэгч нь өөрийн эзэмшлийн хүчин чадал сайтай дэвшилтэт технологийн тоног төхөөрөмжтэй байх бөгөөд өдөрт шинжлэх дээжийн тоо багадаа 200 ширхэг байна. (Хавсралт-2 заасан шинжилгээ)
- ✓ Тоног, төхөөрөмж, машин нь ямар нэг эвдрэл гэмтэлгүй, ажлын тасралтгүй үйл ажиллагаар бүрэн найдвартай хангах бөгөөд дээж тээвэрлэх машин нь жолооны зөв хүрдтэй байна.

ХЭЗГ №01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

- ✓ Гүйцэтгэгч нь нүүрс шинжилгээний үр дүнг өдөр, 7 хоног болон сар тутам захиалагчийн хүссэн загварт оруулан файлаар илгээх бөгөөд сар тутамд цаасаар тамгатай эх хувийг монгол болон англи хэл дээр захиалагч талд хүлээлгэж өгнө.
- ✓ Хайгуулын ажлаар авсан дээж бүрийг 3 жилийн хугацаанд үнэ төлбөргүй зориулалтын дээж хадгалах байранд хадгална. Захиалагч талаас сар тутамд стандартын дагуу дээж хадгалагдаж буйг шалгаж баталгаажуулна.
- ✓ Нүүрсний нарийн шинжилгээтэй холбоотойгоор (Хавсралт-3, 4, 5) тус шинжилгээг эхлүүлэхээс өмнө хийгдэх ажлын дараалал, арга, аргачлал зэргийг захиалагч талд мэдээллэх, сургалтад хамруулах болон харилцан тохирох замаар арга, аргачлалыг өөрчлөх сайжруулах боломжтой байна.
- ✓ Нүүрс шинжилгээний төлбөрийг хайгуулын ажлаар авсан дээжний шинжилгээний гүйцэтгэлээр нэхэмжлэх бөгөөд дутуу дээжний төлбөрийг гүйцэтгэгч тал захиалагч талаас нэхэмжлэх эрхгүй.
- ✓ Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг шинжилгээний хавсралт тус бүрийн үнийн дүнгийн нийлбэрээр тооцох бөгөөд төлбөрийг гүйцэтгэлээр тооцно.
- ✓ Дээж шинжилгээний ажил дууся гэрээ дүгнэсэн акт үйлдэхээс өмнө өрөмдлөгийн ажлын нэгдсэн тайланг захиалагч талд хүлээлгэн өгнө.
- ✓ Гүйцэтгэгч тал нь захиалагч талын 4 геологичийг гадаадад нүүрсний нарийвчилсан шинжилгээний сургалтад хамруулна.

**4.3.2 Ажлын даалгавар**

- ✓ Хайгуулын өрөмдлөгийн нүүрсний дээжүүдэд анхдагч дээжийн шинжилгээ, анхан шатны баяжуулалтын туршилт шинжилгээ, коксын шинж чанар тодорхойлох туршилт шинжилгээ, нэмэлт туршилт шинжилгээ зэрэг 4 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.
- ✓ Гүйцэтгэгч нь нүүрсний анхан шатны техникийн шинжилгээ болон нарийвчилсан шинжилгээ гүйцэтгэх арга аргачлал, гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, танилцуулгын хамт захиалагч талд ирүүлнэ.
- ✓ **Анхдагч дээжийн шинжилгээ** (Хавсралт 2)**:** Өрөмдлөгийн нүүрсний анхан шатны техникийн 20,500 ширхэг Хавсралт 1-д заасан төрөл стандартын дагуу Дээж бэлтгэл, Нийт чийг, Аналитик чийг, Үнслэг, Дэгдэмхий бодисын гарц, Нийт хүхэр, Илчлэг, Барьцалдалт Ж-индекс, Чөлөөт хөөлтийн зэрэг, Харьцангүй нягт тодорхойлох зэрэг шинжилгээг хийж гүйцэтгэх бөгөөд шинжилгээ хийлгэх анхдагч дээжийн тоо хэмжээ нь хайгуулын өрөмдлөгөөр оглогдсон нүүрсний үе

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

давхаргын тоо, түүний зузаанаас хамаарч шинжилгээ хийлгэх дээжийн тоо хэмжээ хэлбэлзэж болно.

- ✓ **Анхан шатны баяжуулалтын туршилт шинжилгээ** (Хавсралт 3): заасны дагуу анхан шатны баяжигдах туршилтыг гүйцэтгэнэ.
- ✓ Анхдагч баяжуулалтын дээжийг 0.25 мм-ийн шигшүүрээр шигшиж шигшүүрийн дээд, доод бүтээгдэхүүний массыг тодорхойлсоны дараа 0.25 мм-ээс дээш ширхэглэлтэй нүүрсэнд баяжуулалтын хөвөх живэх /Floth-Sink/ туршилтыг 1.4 болон 1.6 нягтаар хийж тухайн нягтуудад хамаарах баяжмалын гарцыг тодорхойлно
- ✓ 0.25 мм-ээс доош нунтаг нүүрсэнд Хавсралт 3-ийн Хүснэгт 3.1-д заасан баяжмалд хийгдэх шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэнэ.
- ✓ Анхдагч баяжуулалтын туршилтыг хийж, баяжмалын гарцыг тодорхойлсны дараа: Нүүрсний баяжмалд: Хавсралт 3-ийн Хүснэгт 3.1-д заасан баяжмалд хийгдэх шинжилгээнүүдийг, Завсрын бүтээгдэхүүнд Хавсралт 3-ийн Хүснэгт 3.2-д заасан Завсрын бүтээгдэхүүнд хийгдэх шинжилгээнүүдийг, Хаягдалд Хавсралт 3-ийн Хүснэгт 3.3-д заасан Хаягдал бүтээгдэхүүнд хийгдэх шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэнэ.
- ✓ **Нүүрсний баяжуулалтын цогц шинжилгээ (Хавсралт-4)**-ийн дагуу гүйцэтгэнэ.
- ✓ **Коксын шинж чанар тодорхойлох (Хавсралт-5):** Баяжуулалтын туршилтын үр дүнд үндэслэн баяжмалаас бүрдүүлсэн нүүрсний дээжид коксын шинж чанарыг тодорхойлох (CSR, CRI) шинжилгээг Хавсралт-5-д заасан стандартын дагуу шинжилгээг хийж гүйцэтгэнэ.
- ✓ **Нарийвчилсан шинжилгээ (Хавсралт-5)-д** заасан шинжилгээнүүдийг заасан арга аргачлал, стандартын дагуу гүйцэтгэнэ.
- ✓ Дээрх нарийвчилсан шинжилгээ үнийн санал нь нийт үнийн саналд багтсан байна.
- ✓ Гүйцэтгэгч нь үе шат бүрийн шинжилгээний үр дүнг нүүрсний шинжилгээний техникийн тодорхойлолттой, шинжилгээний төрөл, ISO болон GB стандартын дагуу хийж гүйцэтгэн Захиалагчид үр дүнг цаг алдалгүй хүлээлгэн өгнө.

## 4.4 ЧУЛУУЛАГ, ХӨРС, ГЕОТЕХНИКИЙН ФИЗИК МЕХАНИКИЙН ШИНЖ ЧАНАР ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭХ

### 4.4.1 Ерөнхий шаардлага

- ✓ Гүйцэтгэгч нь Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна.

НУУЦ CONFIDENTIAL "ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК ХЭЗ №01

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

- ✓ Компани нь 5 доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх ба 3-аас доошгүй жил ижил төстэй геотехникийн шинжилгээ, үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагатай байх.
- ✓ Гүйцэтгэгч нь Монгол улсын стандартчилал, хэмжилзүйн газрын "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC 17025 стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, итгэмжлэгдсэн байна.
- ✓ Гүйцэтгэгч нь Олон улсын стандартын шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.
- ✓ Гүйцэтгэгч нь далд уурхайн геотехникийн чиглэлээр дотоодын зөвлөх багтай байна.
- ✓ Гүйцэтгэгч нь далд уурхайн геотехникийн ажлын төлөвлөлт, бичиглэл, дээжлэлт, шинжилгээний үр дүнгийн боловсруулалт, лабораторийн үр дүнгээс чулуулгийн физик механикийн утгыг боловсруулж, зөвлөмж гаргана.
- ✓ Геотехникийн баг нь хайгуулын хээрийн ажилд оролцож, чулуулгийн болон хөрсний дээжийг геотехникийн инженерүүд, болон геологичидтой хамтарч гүйцэтгэх бөгөөд өөрсдийн ажилтнуудын амрах нөхцөл, орон байр, хоол унаа, судалгааны үед шаардлагатай бусад дотоод хэрэгцээгээ өөрийн зардлаар бүрэн хангаж ажиллана.
- ✓ Лабораторийн ажилтан, ажиллагсад нь мэргэжлийн төвшний тодорхой шаардлагыг хангасан, ажлын туршлагатай, мэргэжлийн үнэмлэх, сертификаттай байх бөгөөд тухайн чиглэлээр 5-аас дээш жил ажилласан туршлагатай байх, мэргэшсэн ажилтны хангалттай нөөцтэй, боловсон хүчнээ бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх талаар олон улсын жишигт нийцсэн сургалтын хөтөлбөртэй, дотоод хяналтын системтэй, түүнийгээ хэрэгжүүлж хэвшсэн байх.
- ✓ Гүйцэтгэгч талын лабораторийн барилга байгууламж нь Монгол улсын лабораторийн барилга, байгууламжийн стандарт, норм, нормативийг хангасан байна.
- ✓ Шинжилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, шинжилгээний болон туслах материал нь Хавсралт-6 заасан аргачлал, стандартын шаардлагыг хангасан эсвэл тийнхүү заасаас дээш үзүүлэлттэй байна.
- ✓ Үр дүн нь олон улсын стандарт шаардлагыг хангасан байна.
- ✓ Туршилт шинжилгээ гүйцэтгэх боловсон хүчин нь мэргэжлийн дагуу мэргэшсэн байна.
- ✓ Дээжний үр дүнг бататгах зорилгоор гүйцэтгэгч компани нь тухайн сард шинжилсэн нийт дээжний 4 /дөрөв/ хүртэлх хувийг хөндлөнгийн шинжилгээ

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

гүйцэтгэх бөгөөд өөрийн зардлаар шинжилгээ хийлгэж холбогдох чанарын абсолют зөрүү болон мэдээллийг захиалагч талд файлаар болон цаасаар хүргүүлэх үүргийг хүлээнэ. Хөндлөнгийн лабораторийг Захиалагч тал нь сонгох бөгөөд гүйцэтгэгч тал дээжийг бэлтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө.

- ✓ Хөндлөнгийн дээж шинжилгээний 20-оос дээш хувь нь лаборатори хоорондын зөвшөөрөгдөх стандарт зөрүүнээс их гарсан тохиолдолд түүнийг төлөөлж буй анхдагч дээжийн төлбөрийг Захиалагчаас нэхэмжлэх эрхгүй бөгөөд гэрээг цуцлах үндэслэл болно.
- ✓ Гүйцэтгэгч нь өөрийн эзэмшлийн хүчин чадал сайтай дэвшилтэт технологийн тоног төхөөрөмжтэй байна.
- ✓ Тоног, төхөөрөмж, машин нь ямар нэг эвдрэл гэмтэлгүй, ажлын тасралтгүй үйл ажиллагаагаар бүрэн найдвартай хангах бөгөөд хүн тээвэрлэх суудлын машин нь зөв хүрдтэй байна.
- ✓ Шинжилгээний төлбөрийг өрөмдлөгийн ажлаар авсан дээжний шинжилгээний гүйцэтгэлээр нэхэмжлэх бөгөөд дутуу дээжний төлбөрийг гүйцэтгэгч тал захиалагч талаас нэхэмжлэх эрхгүй.
- ✓ Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг шинжилгээний хавсралт тус бүрийн үнийн дүнгийн нийлбэрээр тооцох бөгөөд төлбөрийг гүйцэтгэлээр тооцно.
- ✓ Дээж шинжилгээний ажил дуусч гэрээ дүгнэсэн акт үйлдэхээс өмнө өрөмдлөгийн ажлын нэгдсэн тайланг захиалагч талд хүлээлгэн өгнө.

**<u>4.4.2 Ажлын даалгавар</u>**

- ✓ Чулуулаг-6210, хөрс-1000, геотехникийн-1400 дээжид тус тус хавсралт 1-т заасан физик-механик шинж чанарыг тодорхойлох туршилт шинжилгээг стандартын дагуу хийж гүйцэтгэх бөгөөд дээжийн тоо хэмжээ чулуулгийн төрөл, дээжийн эвдрэл гэмтлээс хамаарч хэлбэлзэж болно.
- ✓ Гүйцэтгэгч нь нүүрсний анхан шатны техникийн шинжилгээ болон нарийвчилсан шинжилгээ гүйцэтгэх арга аргачлал, гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, танилцуулгын хамт захиалагч талд ирүүлнэ.
- ✓ Чулуулгийн 1 дээжийн физик-механик шинж чанарыг тодорхойлох бүрэн үр дүнг авахын тулд Хавсралт 6-т заасан шинжилгээ тус бүрийн стандартад нийцсэн тооны /нийт дээж бэлтгэх тоо чулуулаг 7-13/ дагуу бэлдцийг туршилтад оруулна.

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ"
ХЭЗГ
№01

- ✓ Захиалагчид чулуулгийн дээжийн физик-механик шинж чанарыг тодорхойлох дээжийг зөв сонгох, туршилт шинжилгээний төлөвлөгөө гаргахад Гүйцэтгэгч мэргэжлийн зөвлөгөө өгнө.
- ✓ Туршилт шинжилгээний үр дүнг гэрээнд заасан техникийн тодорхойлолт, Захиалагчийн захиалгын дагуу шинжилгээний төрөл, стандартыг баримтлан хийж гүйцэтгэн Захиалагчид үр дүнг цаг алдалгүй хүлээлгэн өгнө.
- ✓ Чулуулгийн физик-механик шинж чанарыг тодорхойлох гурван тэнхлэгийн дагуух шахалтын бат бэхийг тодорхойлохдоо 63.5 мм диаметртэй дээжид туршилт хийх зориулалт бүхий төхөөрөмжийг ашиглаж гүйцэтгэнэ.
- ✓ Хөрс болон геотехникийн хурдан чийгээ алддаг дээжүүдийг талбай дээр нь туршилт хийж гүйцэтгэх, хадгалах, тээвэрлэх зохих стандартын дагуу тоног, төхөөрөмж, хүн хүч, ажлын байртай байна.
- ✓ Чулуулгийн шинжилгээтэй холбоотойгоор шинжилгээг эхлүүлэхээс өмнө хийгдэх ажлын дараалал, арга аргачлал зэргийг захиалагч талд мэдээлэх, сургалтад хамруулах болон талууд харилцан тохирох замаар арга, аргачлалыг өөрчлөн сайжруулах боломжтой байна.
- ✓ Гүйцэтгэгч нь лабораторийн туршилт болон ажилтны алдаа, тээвэрлэлтээс шалтгаалж тухайн бэлдцийг туршилт хийх боломжгүй болохоос урьдчилан сэргийлж нөөц бэлдэцийг бэлтгэх бөгөөд гарах зардлыг гүйцэтгэгч тал хариуцна.
- ✓ Захиалагчийн инженер техникийн ажилтнууд нь тээвэрлэлтийн нөхцлийг хянах, дээжийг хүлээлгэн өгөх зорилгоор дээжийг шаардлагатай тохиолдолд дагалдаж явна.
- ✓ Чулуулгийн шинжилгээнд гурван тэнхлэгийн дагуух шахалтын бат бөхийн хязгаар, нэг тэнхлэгийн дагуух шахалтын бат бөхийн хязгаар, суналтын бат бөхийн хязгаар тодорхойлох шинжилгээний 3 бэлдэц бүрийг 1 дээж бэлтгэлээр тооцно. Чийг, нягт тодорхойлох шинжилгээнд дээж бэлтгэл тооцохгүй.
- ✓ Дээжийг дагалдуулан захиалагч нь захиалгын хуудсыг бөглөж өгнө. Гүйцэтгэгч нь дээжийн дугаарыг захиалгын хуудасны дагуу тулган шалгаж тоо болон дугаарын зөрүү гарсан тохиолдолд 24 цагийн дотор Захиалагчийн холбогдох ажилтнуудад мэдэгдэж алдааг засна.
- ✓ Гүйцэтгэгч нь дээжийн хуримтлал үүсэх, шинжилгээний үр дүн хоцрох, түүнээс шалтгаалсан асуудал үүсэхээс сэргийлэн тасралтгүй ажиллах зохион байгуулалтыг хийсэн байх.

НУУЦ CONFIDENTIAL "ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК ХЭЗГ №01

НУУЦ
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

- ✓ Гүйцэтгэгч нь дээжийн шинжилгээний явц (туршилт, үр дүнгийн боловсруулалт, тухайн өдөрт үүссэн нөхцөл байдлын тайлбарын хамт) өдөр тутмын тайланг захиалагч талд цахим шуудангаар хүргүүлнэ.
- ✓ Гүйцэтгэгч нь захиалагч талаас өгсөн загварын дагуу лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн баталгаажуулж, холбогдох инженерүүдэд 7 хоног бүр цахим шуудангаар хүргүүлнэ.
- ✓ Гүйцэтгэгч нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт болон Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартын **/ISO, MNS, ASTM/** дагуу дээж бэлтгэл, шинжилгээг хийх. Ашигласан арга аргачлал, шинжилгээний хариу, дүгнэлтийн хамт тайлангийн бичвэрт дэлгэрэнгүй оруулна.
- ✓ Гүйцэтгэгч тал нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Тавантолгойн ордын уурхайд байрлах өөрийн инженер техникийн ажилчдын хоол, унаа байрлах байрны зардлыг бүрэн хариуцна.

**ХАБЭА-Н ШААРДЛАГА**

- ✓ Далд уурхайн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх хугацаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ХАБЭАБО-ийн холбогдох дүрэм, журам болон зааварчилгааг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.
- ✓ Хээрийн ажлын хугацаанд өөрийн ажилчдын аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцах бөгөөд Гүйцэтгэгч талын мэргэшсэн ХАБ-ын ажилтан, ээлж хариуцсан ажилтан нар өрөмдлөгийн бүхий л хугацаанд хяналт тавьж, ХАБЭАБО-ийн холбогдох дүрэм, журам болон зааварчилгааг үйл ажиллагаандаа мөрдүүлэн ажиллана.
- ✓ Ажил эхлэхээс өмнө ХАБЭАБО-ийн холбогдох журмын дагуу сургалт, зааварчилгаанд ажилчдыг хамруулна.
- ✓ Өрөмдлөгийн үйл ажиллагаатай холбоотойгоор ажилчид болон машин техник, тоног төхөөрөмжүүд нь зохих даатгалд хамрагдсан байхаас гадна "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн ХАБЭАБО холбогдох техникийн шаардлагыг хангасан байх.
- ✓ ХАБЭАБО-ийн шаардлага биелүүлээгүй тохиолдолд ажлыг зогсоох хүртэл арга хэмжээ авна.
- ✓ Үйл ажиллагааг хянах, шаардлага тавьж буй геологичийн өгсөн үүрэг даалгаврын дагуу холбогдох өөрчлөлт, аливаа алдаа дутагдлыг арилгах, сайжруулах арга хэмжээг ээлж хариуцсан ахлах ажилтан нар хариуцан ажиллана.
- ✓ Техник, тоног төхөөрөмж, машин нь ямар нэг эвдрэл гэмтэлгүй, ажлын тасралтгүй үйл ажиллагааг бүрэн найдвартай хангах бөгөөд тээврийн хэрэгсэл нь жолооны зөв хүрдтэй байна.

ХЭЗГ №01
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

- ✓ Ажил эхлэхээс 7 хоногийн өмнө “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Засвар механикийн хэлтсийн үзлэгт хамруулж техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.
- ✓ Гүйцэтгэгч тал нь аливаа үүсэж болох эрсдэл, түүнтэй холбоотой гарах зардлыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- ✓ Хайгуул, судалгааны ажлын үед гарсан аливаа осол, аваар үүнтэй холбоотой эд хөрөнгийн хохирол эвдрэл гэмтлийг гүйцэтгэгч тал өөрийн зардлаар бүрэн хариуцна.

Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлыг KPI-аар оноогоор дүгнэх бөгөөд сар бүрийн ажлын гүйцэтгэл ХАБЭА, байгаль орчин зэрэг үзүүлэлтээр нийт 100 оноо байна. Хасагдах оноо тус бүрийг тухайн сард гүйцэтгэсэн ажлын мөнгөн дүнгийн 0.01%-иар үржүүлэн гүйцэтгэгч талд төлөх төлбөрөөс хасч тооцно. 3 сар дараалан KPI онооны нийлбэр 80 хувиас доош орсон тохиолдолд гэрээг цуцлах үндэслэл болно.

НУУЦ
CONFIDENTIAL
ИЛ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

ИЛ БОЛСОН
НУУЦ
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК



Барилга байгууламжийн зургууд



Зураг-1




Зураг-2





ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

"ЭРДЭНЭС ТАВАНТ...
ХЭЗГ
№01

НУУЦ
CONFIDENTIAL
"...ТАВАНТОЛГОЙ" ХК



Зураг-3

ИЛ БОЛСОН

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ




Зураг-4

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

*Хүснэгт №1*

**Анхдагч дээжийн шинжилгээний төрөл, стандарт**

ИЛ БОЛСОН

| № | Шинжилгээний төрөл | Стандарт аргачлал |
|---|---|---|
| 1 | Дээж бэлтгэх | GB/T 474-2015 |
| 2 | Нийт чийг Wt, ad | MNS ISO 589-2009; GB/T 211-2007 |
| 3 | Аналитик чийг | MNS ISO 11722; GB/T 212-2015 |
| 4 | Үнслэг A ad, d | GB/T 212-2015 |
| 5 | Дэгдэмхий бодис V ad, daf | GB/T 212-2015 |
| 6 | Илчлэг Qgr, ad, ar | MNS ISO 1928:2009; GB/T 213-2008 |
| 7 | Нийт хүхэр St ad, d | MNS ISO 19573; MNS ISO 351; GB/T 214-1996 |
| 8 | Харьцангуй нягт TRD ad, d | MNS ISO 5072; GB/T 217-2008; AS 1038.21.1 |
| 9 | Чөлөөт хөөлтийн зэрэг CSN | MNS ISO 501:2003; GB/T 5448-1996 |
| 10 | Барьцалдах чанар G-index | MNS ISO 15585; GB/T 5447-1997 |

*Схем №1*

**Баяжуулалтын анхан шатны туршилт шинжилгээний схем, шинжилгээний төрөл, стандарт**

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ



НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

Анхдагч баяжуулалтын дээжийн шинжилгээний төрөл

*Хүснэгт №2*

**Баяжмалд гүйцэтгэх шинжилгээний төрөл, стандарт**

ИЛ БОЛСОН

| № | Шинжилгээний төрөл | Стандарт аргачлал |
|---|---|---|
| 1 | Дээж бэлтгэх | GB/T 474-2015 |
| 2 | Нийт чийг Wt, ad | MNS ISO 589-2009; GB/T 211-2007 |
| 3 | Аналитик чийг | MNS ISO 11722; GB/T 212-2015 |
| 4 | Үнслэг A ad, d | GB/T 212-2015 |
| 5 | Дэгдэмхий бодис V ad, daf | GB/T 212-2015 |
| 6 | Илчлэг Qgr, ad, ar | MNS ISO 1928:2009; GB/T 213-2008 |
| 7 | Нийт хүхэр St ad, d | MNS ISO 19573; MNS ISO 351; GB/T 214-1996 |
| 8 | Харьцангуй нягт TRD ad, d | MNS ISO 5072; GB/T 217-2008; AS 1038.21.1 |
| 9 | Чөлөөт хөөлтийн зэрэг CSN | MNS ISO 501:2003; GB/T 5448-1996 |
| 10 | Барьцалдах чанар G-index | MNS ISO 15585; GB/T 5447-1997 |

*Хүснэгт №3*

**Завсрын бүтээгдэхүүнд гүйцэтгэх шинжилгээний төрөл, стандарт**

| № | Шинжилгээний төрөл | Стандарт аргачлал |
|---|---|---|
| 1 | Нийт чийг Wt, ad | MNS ISO 589-2009; GB/T 211-2007 |
| 2 | Аналитик чийг | MNS ISO 11722; GB/T 212-2015 |
| 3 | Үнслэг A ad, d | GB/T 212-2015 |
| 4 | Дэгдэмхий бодис V ad, daf | GB/T 212-2015 |
| 5 | Илчлэг Qgr, ad, ar | MNS ISO 1928:2009; GB/T 213-2008 |
| 6 | Нийт хүхэр St ad, d | MNS ISO 19573; MNS ISO 351; GB/T 214-1996 |
| 7 | Чөлөөт хөөлтийн зэрэг CSN | MNS ISO 501:2003; GB/T 5448-1996 |
| 8 | Барьцалдах чанар G-index | MNS ISO 15585; GB/T 5447-1997 |

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЭГ
№01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

*Хүснэгт №4*

## Хаягдал бүтээгдэхүүнд гүйцэтгэх шинжилгээний төрөл, стандарт

ИЛ БОЛСОН

| № | Шинжилгээний төрөл | Стандарт аргачлал |
|---|---|---|
| 1 | Нийт чийг Wt, ad | MNS ISO 589-2009; GB/T 211-2007 |
| 2 | Аналитик чийг | MNS ISO 11722; GB/T 212-2015 |
| 3 | Үнслэг A ad, d | GB/T 212-2015 |
| 4 | Нийт хүхэр St ad, d | MNS ISO 19573; MNS ISO 351; GB/T 214-1996 |

*Схем №2*

## Иж бүрэн баяжуулалтын туршилт




ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК

Хүснэгт №5

**Нүүрсний нэгж дээжид гүйцэтгэх нэмэлт шинжилгээ**

ИЛ БОЛСОН

| № | Шинжилгээний төрөл | Стандарт аргачлал |
|---|---|---|
| 1 | Пластометрийн X,Y индекс | MNS3666-1984; MNSGB/T 479:2015 |
| 2 | Коксын хатуулаг тодорхойлох | ISO 18894; ASTM 5431; ISO 4023 |
| 23 | Дилатометр | ISO 349-2020 |
| 3 | Гиезлерийн пластометр | ISO 10329-2017 |
| 4 | Нүүрсний үндсэн элементийн шинжилгээ | ISO 19579 |
| 5 | Хортой 5 элемент (Hg, As, F, P, Cl) | MNS ISO 587:2016 ISO:15237-2003, AS 1038.10.1 |
| 6 | Цацраг идэвхит элемент (U, Th, K, Cs) | MNS 5032:2018, MNS 5626:2006 |
| 7 | Үнслэгийн 35 Элементийн шинжилгээ | ASTM D6357-11 |
| 8 | Нүүрсний петрографи | ISO 7404-2; AS2856. 1-2000 |
| 9 | Витринитийн ойлт | ISO7404-5; AS2856.3-2000 |
| 10 | Үнслэгийн хайлах температур | GB/T219-2008 |
| 11 | Нунтаглалтын зэрэг | ISO 5074-2015 |
| 12 | Элэгх индекс | ISO 12900:2018 |
| 13 | Хүхрийн төрөл тодорхойлох | ISO 351:1996 |
| 14 | Голлох ислийн шинжилгээ | ASTM 2795 |
| 15 | Шигшүүрийн шинжилгээ | |

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ
№01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

Талуудын гарын үсэг

НУУЦ
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

**Чулуулгийн дээжид гүйцэтгэх туршилт, шинжилгээний төрөл, стандарт**

*Хүснэгт № 6*

| № | Багц шинжилгээ | Нэгж | Стандарт аргачлал | Шинжилгээ хийгдэх дээжийн тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Дээж бэлтгэх | | ASTM-D4543 | |
| 2 | Чийгшил тодорхойлох | % | ASTM-D2216 | |
| 3 | Нягт тодорхойлох | г/см³ | ASTM-D5030 | |
| 4 | Нэг тэнхлэгийн дагуух шахалтын бат бөхийн хязгаарыг тодорхойлох | кН/МПа | ASTM-D7012 | |
| 5 | Гурван тэнхлэгийн дагуух шахалтын бат бөхийн хязгаарыг | кН/МПа | ASTM-D7012 | |
| 6 | Суналтын бат бөхийн хязгаарыг тодорхойлох | МПа | ASTM-D3967 | |
| 7 | Шилжилтийн бат бөхийн хязгаарыг тодорхойлох | МПа | ASTM-D5607 | 7610 |
| 8 | Хувийн жин | кН/м³ | | |
| 9 | Юнгийн модуль | ГПа | | |
| 10 | Пауссоны коэффифиент | | | |
| 11 | Дотоод үрэлтийн өнцөг | градус | ASTMD7012c, ASTM D2664 | |
| 12 | Барьцалдалтын хүч | МПа | ASTM D5607 | |

**Хөрсний дээжид гүйцэтгэх туршилт, шинжилгээний төрөл стандарт**

*Хүснэгт №7*

| № | Багц шинжилгээ | Нэгж | Стандарт аргачлал | Шинжилгээ хийгдэх дээжийн тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Дээж бэлтгэл | | ASTM-D4543 | |
| 2 | Чийг тодорхойлох | % | MNS 5284; ASTM D6473 | |
| 3 | Нягт тодорхойлох | г/см³ | ASTM D854; ASTM D115 | |
| 4 | Шахалтад үзүүлэх бат бэх чанар | МПа | MNS 3478; ASTM D7012c; ASTM 2938 | |
| 5 | Суналтад үзүүлэх бат бэх чанар | МПа | MNS 3478; ASTM D5607 | |
| 6 | Эзэлхүүн жин | кН/м³ | MNS 2915; MNS ASTM 5182; ASTM D6473 | |
| 7 | Барьцалдалт/ Бутрамтгай чанар | кН/м³ | ASTM D5607 | 1000 |
| 8 | Бутлалтын маркаар шилжүүлсэн чулуулгийн бат бэх чанар | гр/см³ | | |
| 9 | Дотоод үрэлтийн өнцөг | градус | ASTM D7012c; ASTM D2664 | |
| 10 | Хөрсний физик шинжилгээ | | | |

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ
№01



ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL
"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ИЛ БОЛСОН

## ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ҮНЭЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

**1. Өрөмдлөгийн ажил**

| № | Шалгуур үзүүлэлт | Оноо | Хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|
| **ӨРӨМДЛӨГИЙН АЖЛЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ** | | | | |
| 1.1 | Тухайн сарын төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл | 55 | 100% | Тухайн сард төлөвлөсөн өрөмдлөгийн ажлыг хийж гүйцэтгэлээр тооцно. /Хайгуулын ажлын боловсруулалт, төлөвлөлтийн оновчлолтойгоор холбоотойгоор өрөмдлөгийн ажлыг захиалагч талаас түр зогсолт хийсэн хугацааг хасаж тооцно./ |
| 1.2 | Захиалагч талын үүрэг даалгаварын хэрэгжилт | 4 | 100% | Өрмийн мастер болон талбай дээр ажиллаж буй ажилтан нь геологичдын өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлээгүй тохиолдол бүрд 0.1 оноо хасаж тооцно. |
| 1.3 | Дээжийн хайрцаг зөв дугаарласан, дээжийг зөв хайрцагласан байдал | 4 | 100% | Тухайн сард өрөмдсөн цооногийн дээжийн дугаарлалт болон дээжийг эргүүлж хайрцагласан тохиолдолд 0.1 оноо хасна. |
| 1.4 | Өрмийн геологичдын ээлжийг тогтсон цагт сольсон байдал. | 4 | 100% | Захиалагч талын батлагдсан хувиарын дагуу өдрийн болон шөнийн ээлжийн солино. Тухайн сарын ээлжийг цагтаа сольсон хувиар тооцно. |
| 1.5 | Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх ажилтнуудын ажиллах хүч. | 4 | 100% | Ажиллах хүчний байдлаас болж өрөмдлөгийн ажил удаашрах, сул зогсолт тус бүрд 0.2 оноо хасаж тооцно. |
| 1.6 | Гүйцэтгэгчийн техник, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд өөр техник, тоног төхөөрөмжөөр сольж ажлыг тасралтгүй, цаг алдахгүй явуулах арга хэмжээг нэн даруй авах. | 4 | 100% | Өрөмдлөгийн ажил хойшлосон хоног тус бүрд 0.2 оноо хасаж тооцно. |
| 1.7 | Гэрээний үүргийн хэрэгжилт | 5 | 100% | Гүйцэтгэгч талын гэрээнд заасан үүргийн биелэлтийн хувиар тооцно. |
| **НИЙТ ДҮН** | | **80** | **100%** | |

ХЭЗГ
№01

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

## ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ДҮНД ЭЗЛЭХ ОНОО

| ХАБЭА-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | | | Оноо | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| **Хоцрогдох үзүүлэлт:** | | | **10** | **100%** |
| 1 | Осол, ОДТ, ӨЭ, Гэмтэл, Эмнэлэгийн тусламжийн тоо: | | 6 | 100% |
| | 1.1 | Осол (0) | 2 | 100% |
| | 1.2 | ХАГ (<1) | 2 | 100% |
| | 1.3 | Бүртгэгдэхүйц гэмтэл (<1) (*ХАГ + Эмнэлэгийн тусламж+ХАШГ*) | 2 | 100% |
| **Тэргүүлэх үзүүлэлт:** | | | **3** | **100%** |
| 2 | 2.1 | ХАБ-ын болон бусад журам, горим, заавар зөрчсөн тохиолдолд | 3 | 100% |
| **Гэрээний ерөнхий заалтын хэрэгжилт:** | | | **1** | **100%** |
| 3 | 3.1 | Нэмэлтээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт | 1 | 100% |
| **НИЙТ ДҮН** | | | **10** | **100%** |

Анхаар: Үйлдвэрлэлийн осол гаргавал, мөн ноцтой зөрчил, ОДТ, ӨЭ, гэмтлийг нуун дарагдуулсан нь нотлогдвол тухайн сарын гүйцэтгэсэн ажлыг KPI үнэлгээгээр үнэлэхгүй, бүхэлд нь "0"-лэнэ.

Тухайн осол гарсан сарын ажил гүйцэтгэлийн үнэлгээг бусад үзүүлэлтээс үл хамааран шууд 0%-иар тооцно.
Хөдөлмөрийн чадвараа түр алдах осол гарсан тохиолдолд ажил гүйцэтгэлийн үнэлгээнээс -4 оноо хасна.
Эмнэлгийн тусламж авсан гэмтэл гарсан тохиолдол бүрт ажил гүйцэтгэлийн үнэлгээнээс -2 оноо хасна.
Салбарт мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн аюулгүй байдлын болон бусад журам зөрчсөн, ОДТ, ӨЭ, зөрчил гаргасан тохиодолд бүрт -2 оноо хасна.

Нэмэлтээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт

| 95-100% | **100%** | 75-94 | **75%** | 50-75% | **50%** | 50 доош | **0%** |
|---|---|---|---|---|---|---|---|

## ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ДҮНД ЭЗЛЭХ ОНОО

| БАЙГАЛЬ ОРЧИН, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | | | Оноо | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | **Сөрөг нөлөөллийг бууруулах** | | **1.0** | **100%** |
| 2 | **Нөхөн сэргээлт** | | **6.0** | **100%** |
| 3 | 3.1 | Өрөмдсөн цооногуудын техникийн нөхөн сэргээлт | 2.0 | 100% |
| | 3.2 | Өрөмдсөн цооногийн хаягжуулалт | 2.0 | 100% |
| | 3.3 | "Тонн баялаг-Нэг мод" хөтөлбөрийн хүрээнд мод тарих | 2.0 | 100% |
| 4 | **Хог хаягдал** | | **2.0** | **100%** |
| 5 | **Асгаралт** | | **1.0** | **100%** |
| 6 | **Байгаль орчны зөрчил** | | | |
| | 5.1 | Шимт хөрс | | |
| | 5.2 | Асгаралт, аюултай бодис | | |
| | 5.3 | Усны хэрэглээ, ашиглалт | | |
| | 5.4 | ТТАМ зөвгөөрөлгүй ашиглахгүй байх | | |
| | 5.5 | Хэмжилтийн нэгдмэл байдал | | |
| **НИЙТ ДҮН** | | | **10** | **100%** |

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК ХЭЗГ №01

---------- Талуудын гарын үсэг ----------

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ
CONFIDENTIAL

## 2. Цооногийн геофизикийн ажил

| № | Шалгуур үзүүлэлт | Оноо | Хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|
| ЦООНОГ ТУС БҮРИЙН ХЭМЖИЛТ ГҮЙЦЭТГЭХ ҮЗҮҮЛЭЛТ | | | | |
| 1.1 | Dual density (short-spaced and long-spaced) хэмжилт | 11 | 100% | Тухайн сарын цооногийн геофизикийн хэмжилтийн гүйцэтгэл болон боловсруулалтын ажлын үр дүнгээр дүгнэнэ. Хэмжилт гүйцэтгээгүй 5 метр тутамд 0.1 оноо хасаж тооцно. Мөн боловсруулалтын үр дүн нь чанарын шаардлага хангаагүй тохиолдолд цооног тутамд 1.0 оноо хасаж тооцно. /Геологийн хүндрэлээс шалтгаалж хэмжилт гүйцэтгэж чадаагүй туүш метрийг хасаж тооцно./ |
| 1.2 | Natural gamma хэмжилт | 11 | 100% | |
| 1.3 | Acoustic Televiewer /Optic/ эвсэл Dipmeter хэмжилт | 11 | 100% | |
| 1.4 | Dual resistivity PR хэмжилт | 11 | 100% | |
| 1.5 | Down hole survey (deviation and azimuth) хэмжилт | 11 | 100% | |
| 1.6 | Caliper, Deviation (three arm) хэмжилт | 11 | 100% | |
| 1.7 | Sonic хэмжилт | 11 | 100% | |
| 1.8 | Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх ажилтнуудын ажиллах хүч. | 3 | 100% | Ажиллах хүчний байдлаас болж цооногийн геофизикийн хэмжилтийн ажил удааршрах, сул зогсолт тус бүрд 0.1 оноо хасаж тооцно. |
| 1.9 | Гүйцэтгэгчийн техник, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд өөр техник, тоног төхөөрөмжөөр сольж ажлыг тасралтгүй, цаг алдахгүй явуулах арга хэмжээг нэн даруй авах. | 5 | 100% | Цооногийн геофизикийн ажил хойшлосон хоног тус бүрд 0.5 оноо хасаж тооцно. |
| 1.10 | Гэрээний үүргийн хэрэгжилт | 5 | 100% | Гүйцэтгэгч талын гэрээнд заасан үүргийн биелэлтийн хувиар тооцно. |
| **НИЙТ ДҮН** | | **85** | **100%** | |

"ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ" ХК
ХЭЗГ
№01
ИГ БОЛСОН
ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

НУУЦ

**ГЭРЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ДҮНД ЭЗЛЭХ ОНОО**

| ХАБЭА-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | | | Оноо | Үнэлгээ |
|---|---|---|---|---|
| **Хоцрогдох үзүүлэлт:** | | | **10** | **100%** |
| 1 | Осол, ОДТ, ӨЭ, Гэмтэл, Эмнэлэгийн тусламжийн тоо: | | **6** | 100% |
| | 1.1 | Осол (0) | 2 | 100% |
| | 1.2 | ХАГ (<1) | 2 | 100% |
| | 1.3 | Бүртгэгдэхүйц гэмтэл (<1) (*ХАГ + Эмнэлэгийн тусламж+ХАШГ*) | 2 | 100% |
| **Тэргүүлэх үзүүлэлт:** | | | **3** | **100%** |
| **2** | 2.1 | ХАБ-ын болон бусад журам, горим, заавар зөрчсөн тохиолдолд | **3** | 100% |
| **Гэрээний ерөнхий заалтын хэрэгжилт:** | | | **1** | **100%** |
| **3** | 3.1 | Нэмэлтээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт | **1** | 100% |
| **НИЙТ ДҮН** | | | **10** | **100%** |

Анхаар: Үйлдвэрлэлийн осол гаргавал, мөн ноцтой зөрчил, ОДТ, ӨЭ, гэмтлийг нуун дарагдуулсан нь нотлогдвол тухайн сарын гүйцэтгэсэн ажлыг KPI үнэлгээгээр үнэлэхгүй, бүхэлд нь "0"-лэнэ.

